



Журандаад хэн ч бичихгүй



1982 ОНЫ УТГА ЗОХИОЛЫН САЛБАР ДАХЬ НОБЕЛИЙН ШАГНАЛТАН
ГАБРИЭЛЬ ГАРСИЯ МАРКЕС

Хурандаад хэн ч бичихгүй

Зохиолч: Г.Г.Маркес

Орчуулсан: О.Чинбаяр

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Габриэль ГАРСИЯ МАРКЕС

(1928)

1982 оны Утга зохиолын салбар дахь Нобелийн шагналтан

Колумбийн нэрт зохиолч, сэтгүүлч Габриэль Гарсия Маркес Карибын тэнгисийн хөвөөнд орших Аракатака гэдэг жижиг хотод цахилгаан мэдээний газрын албан хаагчийн өнөр өтгөн гэр бүлд төржээ. Гарсия Маркес багадаа эмээ, өвөө дээрээ өссөн байна. Тэдний ярьж өгдөг байсан санаанд багтамгүй түүх, үлгэр, домгууд ирээдүйн зохиолчийн цаашдын уран бүтээлд тодорхойлох нөлөө үзүүлсэн аж. 1947 онд Гарсия Маркес Колумбийн их сургуулийн хуулийн факультетад элсч орсон бөгөөд энэ үед түүний анхны өгүүллэгүүд хэвлэгдэн гарав. Тэрбээр янз бүрийн хэвлэлийн газарт ажиллаж сэтгүүлч болох эхлээ тавьжээ. Колумбийн усан цэргийн флотын хөлөг онгоцоор хулгайн бараа тээвэрлэж буй тухай “Ажиглагч” сонинд нийтлэл бичсэнээс болж бөөн шуугиан дэгдэн сониныг хааж, харин сэтгүүлч ямар ч мөнгөгүй Европт үлдсэн байна.

Европоос эргэж ирээд Гарсия Маркес Кубын Засгийн газрын Пренса Латина мэдээллийн агентлагт хоёр жил ажиллав. 1961 оноос тэрбээр Мехико хотод сэтгүүл зүй, кино зохиолоор хоолоо олж амьдарчээ. Энэ бүх хугацаанд зохиолч өөрийн гэсэн хэв маягийг уйгагүй эрэлхийлж байсан аж. “Хурандаад хэн ч бичихгүй” (1958) тууж, “Ээжийн оршуулга” өгүүллэгийн түүвэр зэрэг нь уншигч олонд хүрэв. 1967 онд тэр өөрийн анхны томоохон бүтээл, 20-р зуун аугаа зохиолын нэг болох “Зуун жилийн ганцаардал” -аа бичиж дуусгасан юм. Энэ нь Макондо хэмээх зохиомол суурингийн аж амьдралын түүх юм. Эл номыг анх найман мянган ширхэг хэвлэн нэг жилийн дотор борлуулах төлөвлөгөөтэй байсан ч номын дэлгүүрүүдийн лангуун дээрээс хэдхэн хоногийн дотор алга болжээ. Ингэж уг түүхэн домогт романы ялгуусан амжилт эхлэсэн байна.

Романыг Гарсия 1936 онд хайртай өвөг эцэг нь нас барсаны дараа буюу арван найман настайдаа эхлүүлсэн боловч арай балчир байна гэдгээ ойлгон орхижээ. Ийнхүү эл зохиолын зорьсон санаа гуч орчим жил боловсорч байгаад сая нэг томоохон бүтээл болсон юм. Олон шүүмжлэгч энэ романыг “Сервантес”-аас хойш испани хэл дээр бичигдсэн хамгийн аугаа зохиол гэж дүгнэсэн аж. Энэхүү алдарт зохиол маш амжилттай борлогдож байсан тул Гарсия “Гарамгай хүний намар” /1975/ нэртэй сургааль роман бичжээ. Элзохиолдоо Латин Америкийн засаглал, дарангуйлагчдын дэглэмийн мөн чанарыг дэлгэсэн байна. Үүний дараа “Зарлагдсан үхпийн товчоон” /1981/ ном гарч, жилийн дараа Гарсия Маркес Утга зохиолын салбар дахь Нобелийн шагналыг “бодит байдал, хийсвэр зүйлийг тусгасан тул” хүртэв. Энэ бүх хугацаанд тэрбээр Мехико /Мексик/ хотод ажиллаж, амьдарч байгаа бөгөөд сэтгүүл зүйд хүчээ сорьж байгаа аж. Түүний бүтээлүүд Хорхе Луис Борхес, Хулио Кортасарын зохиолуудын хамт үлгэр,оньсого мэт Латин Америкийн ертөнцийг бүхэнд нь нээж үзүүлсэн билээ.

Хурандааг кофены тагийг авахад тэнд ердөө цайны ганцхан халбаганаас хэтрэхээргүй юм үлдсэн байлаа. Тэрбээр халуун ширмэн дээрээс савтай буцалсан усыг авч талыг нь асгаад савны ёроолд хатсан кофены шавхрууг сэгсэрч халуун усанд хийлээ. Кофе болох зуурт тэр галд түлэгдсэн тоосгон зуухны дэргэд суугаад тэрхэн үест түүний гэдсэнд мөөг, хортой ургамал хэрхэн ургаж буйг төсөөлөхийг оролдов.

Аравдугаар сар. Олон арван ийм л өдрийг элээсэн түүний хувьд давталт мэт хуучин нэгэн өглөөтэй дахин золголоо.

Иргэний сүүлчийн дайн дууссанаас хойш бүхэл бүтэн тавин зургаан жил өнгөрсөн боловч хурандаа ямар нэгэн зүйлийг хүлээсээр байжээ. Аравдугаар сар бол түүний хувьд хүлээж байсан зүйлийнх нь ердөө багашаархан хэсэг төдий ажээ. Эхнэр нь түүнийг унтлаганы өрөөнд гартаа аягатай кофе барьсаар орж ирэхийг харуут үүдний ширдгийг засав. Өнгөрсөн шөнө түүний багтраа өвчин хөдлөн унтаж чадаагүй тул одоо нойр нь учиргүй их хүрч байлаа. Тэрээр түүний аягыг авахаар өндийхдөө,

-Чи зүгээр үү? хэмээн асуувал,

-Би уучихпаа. Тэнд бас нэг халбага шахуу юм үлдсэн гэж хурандаа хариуллаа.

Энэ үед оршуулгын ёслолын хонхон дуу хадав.

Хурандаа оршуулгын талаар бараг мартчихсан байлаа. Эхнэрээ кофе уух зуур тэрбээр хананд өлгөөтэй дүүжин орны оосрыг мулталж хуйлаад хаалганы ард өлгөв. Эхнэр нь ч мөн талийгаачийн тухай бодолд автжээ.

-Тэр 1922 онд төрсөн юм. Яг манай хүүгээс нэг сар дүү шүү дээ гэв. Дөрөвдүгээр сарын долоон байх аа...

Тэрээр кофег бага багаар оочлон уухад амьсгал нь үе үе хэн тасалдана.

Энэ эмэгтэйг өвчин ороосноос хойш түүний яс сийрэгжиж, гэрэлтэх нь холгүй болоод амьсгал нь тасалддаг болсноос тэр нэг хэвийн хэмнэлээр ярих тул тавьсан асуулт нь яг санал мэт сонсогддог билээ.

Эмэгтэй кофегоо ууж дуусмагц мөнөөх л талийгаачийн тухай бодолдоо автлаа.

-Аймшигтай юм даа, хэрэв чамайг аравдугаар сард оршуулсан бол ч хэмээн түүнийг хэлэхэд нөхөр нь огт анзаарсан шинжгүй байв. Тэрбээр цонх онгойлголоо. Үнэхээр л аравдугаар сар болсон нь илт, хатаж буй авч бас чиг шүүслэг хэвээр байгаа ургамал, газраар мөлхөх чийгийн улаан зэргийг хараад гагцхүү энэ сард л түүний ходоод гэдэс нь эвгүйрхдэг болохыг хурандаа санаад,

-Миний яс хүртэл чийг даажээ хэмээн өгүүлэв.

-Өвөл бол өвөл шүү дээ. Бороошиж эхэлмэгц л би чамд шөнө унтахдаа зузаан ноосон

оймсоо өмсч бай гэж үргэлж л үглэдэг биз дээ гэж эхнэрийгээ өгүүлэхэд,

-Би долоо хоног шахуу оймстой унтсан шүү дээ гэв.

Бороо зогсоо зайгүй зүсэрч байлаа. Хурандаа ноосон хөнжлөө нөмөрч дүүжин орон дээрээ хэвтэхийг хүснэ. Гэвч хаяанд сонстох хүрэл хонхны чимээ хүссэн хүсээгүй оршуулгын тухай сануулах ажээ.

-Яая ч гэхэв, аравдугаар сар юм чинь гэж амандаа бувгнасаар тэр цонхноос холдов.

Энэ агшинд орны хөлнөөс хүлж орхисон азарган тахианы тухай санав. Тэр бол жинхэнэ зодоонч тахиа билээ. Хурандаа хоосон аягаа гал тогоонд аваачиж тавиад өрөөндөө буцан ирж ханын цагийг тааруулав.

Зочны өрөө унтлагын өрөөг бодвол хавьгүй уужим учир багтраа өвчтэй хүнд амьсгалахад дөхөмтэй санж. Цагны эсрэг талын хананд нүцгэн биедээ нимгэн алчуур нөмөрч бөөн сарнайн дунд завинд суугаа бүсгүйн зураг өлгөөтэй харагдана.

Түүнийг цаг тааруулах үед найман цагт хорин хором дугуу байлаа. Дараа нь гал тогоонд орж тавагтай усыг асгаад атга эрдэнэ шиш хийж тахиагаа хооллов. Нэг мэдэхнээ хэдэн жаал хашааны завсраар орж ирчихсэн гал тогоонд өнөөх тахиаг дуугүйхэн тойрон сууж түүний хэрхэн хооллохыг сонжицгоож байв.

-Түүнийг мөрөөр нь байлгацгаа, удаан шинжих нь наад тахианд чинь ямар ч ашиг тус өгөхгүй шүү хэмээн хурандааг зэмлэвэл хүүхдүүд түүний хэлснийг огт сонссон янзгүй, бүр суусан газраасаа ч хөдөлцгөөсөнгүй. Харин ч тэдний нэг нь аман хуур гаргаж нэгэн дэгжин аялгуу тоглож эхлэв.

-Өнөөдөр дуу хөгжим тоглож болохгүй ээ. Хотод буяны ажил явагдаж байна гэж хурандаа хүүд хэллээ.

Хүү аман хуураа өмднийхөө халаасанд хийх үед хурандаа хөдөөлүүлгийн ажил явдалд өмсдөг хувцсаа солихоор хажуу өрөөнд оров.

Эхнэрийн өвчин хөдөлсөн тул иймэрхүү ёслолд хаяахан өмсдөг цагаан костюм нь индүүдлэггүй байсанд хурандаа хэсэг бодолхийлснээ хуримаасаа хойш онцгой тохиолдолд л өмсдөг байсан хар цэмбэн костюмаа санаж, нэлээд хайсны эцэст хүр хорхойноос хамгаалан сонингийн цаасанд нямбайлан боож авдрын ёроолд хийснийг олов.

Эхнэр нь талийгаачийн тухай л бодсоор байлаа.

-Одоо тэр Агустинтэй уулзсан байх даа. Гэхдээ хүүгийн минь үхлийн дараа бидэнд юу тохиолдсоныг битгий л хэлж үзээсэй билээ хэмээн өгүүлвэл,

-Тэд одоо уулзчихсан бол азарган тахианы тухай л маргалдаж байгаа биз дээ гэж хурандаа хариулав.

Тэрбээр маш том хуучирсан шүхрийг авдарнаас олжээ. Цагтаа эхнэр нь хурандаагийн харьяалагддаг намын хандивын төлөө зохион байгуулсан сугалаанаас түүнийг хожсон юм гэдэг. Тэр үдэш бороо орсон хэдий ч тэд эрүүл агаарт тоглолт үзсээр гэртээ ч хариагүй бөгөөд тэр үед дөнгөж найман нас хүрч байсан хүү Агустины хамт тэрхүү далбагар том шүхрийн дор сууцгааж тоглолтыг дуустал үзсэнсэн.

Одоо бол шал өөр... Агустин хорвоогийн мөнх бусыг үзүүлж, сайхь хуучирсан шүхрийн зарим хэсгийг хүр хорхой иджээ.

-Манай алиалагчийн шүхэр ямар болсныг хараач. Одоо энэ цоорхой нүхнүүдээр нь од тоолоход хялбар болсон байна шүү гэж егөөдөөд инээвхийллээ. Харин эхнэр нь шүхрийг харсан ч үгүй.

-Одоо ч бүх юм мууджээ. Бид ч гэсэн амьдаараа өмхийрч байна гэж тэр шивнэлээ. Тэрээр талийгаачийн тухай бодоход саад болж буй бүхнийг мартахын тулд нүдээ анив.

Толь гэж хэдийнэ байхгүй болсон тул хурандаа таамгаар сахлаа хусч дуусмагц хувцаслаж эхлэв. Өмд нь бариу гэжжигтэйхэн байлаа. Тэр ердөө бүс зүүдэггүй нэгэн. Хуучирч муудсан хатуу цаас шиг өнгөтэй цамц нь зэс товчоор товчлогдоно.

Цамцны зах нь урагдсан тул хурандаа зангиа зүүхээ больсон ч яг л ариун зан үйл хийж буй мэт хувцаслаж байлаа.

Түүний тунгалаг нимгэн арьстай ясархаг гар энд тэндгүй алаг цоог бор өнгийн толбонд идэгджээ.

Чийдсэн гутлаа өмсөхөөс өмнө наалдсан шаврыг нь арчиж буй нөхрөө харахад эхнэрт нь тэрбээр яг л хуримын өдөр байсан шигээ үзэгдсэн боловч энэ мөчид тэр өөрийн эр нөхрийг ямар их хөгширсөн болохыг ойлгов.

-Чи ямар нэгэн онцгой үйл явдалд оролцох гэж байгаа юм шиг харагдаж байна шүү гэж түүнийг өгүүлэхэд,

-Оршуулга чинь тэгээд үйл явдал мөн биз дээ? Амьд яваа энэ олон жилийн туршид анх удаа хүн зуурдаар нас нөгчлөө шүү дээ, хөгшин минь гэж хурандаа хариу барив.

Есөн цагаас хойш бороо татарчээ. Хурандааг гарахаар завдтал эхнэр нь гараас чангааж,

-Ядаж үсээ самна л даа хэмээн хэллээ.

Хурандаа өөрийн ширүүн үсээ самнахыг оролдсон боловч тусыг эс олов.

-Би яг л тоть шиг харагдаж байна уу? гэж асуулаа.

Эзэгтэй түүнийг дээрээс доош нэгд нэгэнгүй харав. Түүнд хурандаа тотьтой адил санагдсангүй. Тэрбээр туранхай авч хөдөлгөөнтэй хүн байлаа. Түүний сэргэлэн цовоо харц ямар нэгэн хуучны үхээнц байдлыг үл санагдуулна.

-Бүх юм зүгээр ээ гэж нөхрөө өрөөнөөс гарах үед тэрээр бувтнав.

Тэд дал модны навчсан хана, дээвэр бүхий хотын захын нэгэн байшинд амьдардаг билээ. Гадаа саяхан бороо орсон мэт чийг үнэртэнэ. Хурандаа гудамж тойрон шавааралдсан олон жижиг байшингийн зүг алхав.

Төв гудамж хүрэхүйд бие нь халуу шатаж эхэлснийг тэр мэдэрлээ. Хар өмсгөлтэй хүүхнүүд байшингийн үүдэн дээр сууцгааж оршуулгын ажиллагааг ажиглацгаана.

Хурандааг талбай дээр ирэхэд дахин хүйтэрч эхлэв. Бильярдны газрын эзэн түүнийг гараараа даллаж:

-Хурандаа, түр хүлээгээрэй. Би танд шүхэр өгье гэж хашгирав.

Хурандаа түүний зүг харсан ч үгүй,

-Баярлалаа, надад ингээд явах нь сайхан байна гэв.

Талийгаачийг гэрээс нь гаргаагүй байлаа. Цагаан костюм, хар зангиа зүүсэн эрчүүд шүхрээ дэлгэн үүдэн дээр зогсоцгоох ба тэдний нэг шалбааг дээгүүр харайж буй хурандааг харуут:

-Ах минь, та нааш ирээч дээ хэмээн дуудлаа.

-Баярлалаа, дүү минь гэж хурандаа хариулаад, талийгаачийн эхэд эмгэнэл илэрхийлэхээр шуудхан дотогш оров. Эхлээд олон төрлийн цэцэгсийн үнэрийг мэдэрлээ. Дараа нь маш их бүгчимхэн болов. Тэрбээр унтлагын өрөөнд цугларагсдыг яран дотогш орохоор зүтгэлээ. Энэ үедхэн нэгэн түүний мөр рүүдэмнэн түлхэж уй гашууд автсан царайтай хүмүүсийн дундуур зүсэн орохуйд талийгаачийн томоо хамрын нүх нүднээ тусчээ. Дэргэд эх нь суух агаад дал модны навчсан дэвүүрээр ялаа үргээнэ. Харин бусад хар өмсгөлтэй эмэгтэйчүүд талийгаач руу яг л усны урсгад мэт гөлөрцгөөж байлаа.

Хүмүүсийн дун даасхэн нэгний уйлах сонсдов. Хурандаа нэгэн эмэгтэйг замаасаа холдуулж талийгаачийн ээжид дөхөн очоод түүний мөрөн дээр гараа зөөлөн тавилаа. Тэр гэдсээ баздахыг тэвчин шүдээ зуув.

-Миний гүн эмгэнэлийг хүлээн авна уу?

Эх тэргүүнээ өндийлгөсөнгүй боловч байдгаараа мэгшиж гарлаа. Хурандаа зогтусав.

Үймэрч самуурсан хүмүүс уйлах чимээнд бал магдан түүнийг цогцос руу түлхэж буй мэт санагдана. Хана руу гараараа тулах гэсэн боловч чадсангүй. Харин дэргэд байгаа хүмүүстэй шахцалдаж байлаа.

-Болгоомжтой байгаарай, хурандаа! гэж хэн нэгэн түүний чихэнд аяархан шивнэх шиг санагдахад эргэн харвал талийгаачтай харц тулгарах шиг болжээ. Эхлээд түүнийг таньсангүй. Амьддаа бүрлээч биерхүү агаад хөдөлгөөнтэй нэгэн байсан бол одоо цагаан даавуунд биеэ

ороож, гартаа модон бишгүүр барьсан байхыг харахад мөн л өөртэй нь адил ихэд балмагдсан дүртэй үзэгдэнэ. Хурандааг толгойгоо өндийлгөн бага ч гэсэн агаар амьсгалахыг оролдоход авс нь цэцгээр хэлхсэн давалгаа дундуур хөвөх мэт санагдахад хурандаагийн хөлс чийхрав. Түүний үе мөч янгинаж байлаа.

Хэдэн хормын дараа гудамжинд гарч бороонд норон зогсож байхад хэн нэг нь түүний гараас атгаж “Түргэлээрэй, би таныг хүлээж байсан” гэв. Тэр бол түүний нас барсан хүүг загалмайлан эцэг дон Сабас гэгч байсан ба улс төрийн мөрдлөгөөс зугтаж тус хотод амьдарч байгаа намын удирдагчдаас үлдсэн цорын ганц хүн байв.

-Танд их баярлалаа гэж хурандаа хэлээд бороонд норсоор дуугүйхэн алхав. Найрал хөгжим оршуулганы ая тоглоно. Хурандаа үлээвэр хөгжмийн зэмсэг сонсдохгүй байгааг анзаарсан агаад талийгаачийг үнэхээр өнгөрчээ гэдгийг сая л нэг ухаарчээ. “Хөөрхий зайлуул” гэж тэр дотроо шивнэв. Ноён Сабас бүгшүүлэн ханиалгав. Зүүн гартаа шүхэр барьсан тэр хүн хурандаагаас намхан тул шүхрээ өөрийн толгойноос хамаагүй дээр өргөн зогсоно. Оршуулгын цуваа талбайг орхин одоход эрчүүд хоорондоо ярилцаж эхлэв. Ноён Сабас хурандаа руу их л эмгэнэлтэйгээр харснаа:

-Танай азарган тахиа дажгүй биз? гэв.

-Яахав дээ, байж л байна.

Энэ үед тэрбээр хэн нэгний орилохыг сонсов. -Талийгаачийг аваад та нар хаашаа орох гээд байна аа?

Хурандааг толгой өндийлгөхөд цэргийн хуарангийн тагтан дээр яг л уран илтгэгч мэт чэрби зогсох аж.

Унтлагын өмд, цамц угласан чэрби сахпаа огт хусаагүй агаад нүд нь бүлцийсэн байлаа. Хөгжимчид тоглохоо больж, хэсэг мөчийн дараа Анхель ламтныг түүнд ямар нэгэн зүйл хэлж байгааг хурандаа сонсов. Тэрбээр шүхэр балбах борооны цохилтын хажуугаар тэдний ярианд чих тавьж эхэллээ.

- Тэнд юу болоод байгаа юм бэ? хэмээн ноён Сабас асуув.

- Цэргийнхэн хуарангийн дэргэдүүр явж болохгүй л гэж байна.

- Аан, би үүнийг таг мартчихаж. Бид үргэлж л бүслэлтийн байдалд байгаа гэдгээ мартаж орхиж хэмээн ноён Сабас уулга алдав.

-Гэхдээ бид чинь ямар хувьсгал хийж байгаа биш. Энэ бол зүгээр л нэг ядуу хөгжимчний оршуулга шүү дээ...

Оршуулгын цуваа чиглэлээ өөрчлөн ядуусын хороолол дундуур өнгөрөх үед эмэгтэйчүүд дэмий л хумсаа мэрж тэднийг харцаараа үдэж байлаа. Дараа нь гудамжны төв хэсгээр өнгөрөхөд элдэв магтаал, талархал хийгээд хагацлын үгсийг талийгаач сонсож байгаа

гэдэгт итгэх мэт чулуудав. Оршуулгын газар ирэхэд хурандаагийн дотор эвгүйрхлээ. Ноён Сабас авсыг дамжилж яваа хүмүүст зам чөлөөлж өгөхөөр түүнийг хана руу шахсанаа арагш эргэн харж инээмсэглэхэд хурандаагийн царай яг л хүн чулуу шиг болсон байлаа.

-Та зүгээр үү? Аравдугаар сар гарчээ гэхэд хурандаа санаа алдав. Буцахдаа тэд нөгөө л гудамжаараа явцгаажээ. Бороо зогсоход тэнгэрийн царай гүн цэнхэр болсон аж. Одоо ч бороо зогслоо доо хэмээн бодож биеэ арай л дээрдсэнийг мэдрэх авч өөрийн мэдрэхүйг сонсохыг хүсч байлаа. Ноён Сабас түүний бодлыг сарниулж:

-Та эмчид үзүүлбэл зүгээргүй юу? гэв.

-Би өвдөөгүй байна. Харин аравдугаар сар гарахаар миний гэдэс дотрыг зэрлэг араатнууд тасчин идэж байгаа мэт надад санагддаг юм.

-Аа, тийм үү? гээд ноён Сабас гэрийнхээ үүдэн дээрээс салав.

Ёслолын костюмаас салахын түүс болсон хурандаа гэрийн зүг яаравчлан алхлаа. Гэвч удалгүй булангийн цаана байдаг мухлагаас лаазтай кофе, азарган тахиандаа хагас фунт эрдэнэ шиш авахаар гэрээсээ гарав. Уг нь хурандаа бүх л өдрийг дүүжин орон дээрээ өнгөрөөхийг хүсч байсан боловч тахиатайгаа зууралдаж өнжив.

Бороо оролгүй хэд хонолоо. Өнгөрсөн долоо хоногийн дотор түүний гэдсэн дэх зэрлэг ургамал улам их ургав янзтай. Шөнө нойргүй хонох үедээ багтраа өвчнөөр шаналах эхнэрийнхээ таагүй амьсгалахыг сонсож өнгөрөөнө. Гэвч дараагийн баасан гаригт аравдугаар сар жаахан амьсгаа авах боломж олгов. Агустины найз гуталчид, азарган тахианы зодоон сонирхогчид энэхүү боломжийг ашиглан тахиаг нь харахаар ирцгээжээ. Тэр маш сайн бэлтгэлтэй харагдана. Тэднийг явсан хойно хурандаа эхнэрийнхээ өрөөнд оров. Тэдний ирсэн явдал түүнд хамаагүй бус байжээ.

-Тэд юу ярьж байна?

-Их л баяртай байна. Манай тахианд бооцоо тавихаар мөнгөө хуримтлуулж байна гэнээ.

-Манай тахианы юунд нь болдог байна аа? Тэр чинь үзлийн амьтан шүү дээ гэж эхнэр нь хэлэв.

Түүнийг энэ хавьдаа л хамгийн сайн нь гэж тэд ярилцаж байна. Доод тал нь 50 песо хүрнэ дээ гэж хурандаа өгүүлэв. Энэ бол хүүгийнхээ азарган тахиаг авч үлдэхийн тулд эхнэрээ итгүүлэх чухал нотолгоо болно гэдэгт тэр итгэлтэй байлаа.

-Чиний наад уран зөгнөл чинь хэрээс хэтэрлээ. Эрдэнэ шиш дууссан цагт бид түүнийг өөрийнхөө элгээр тэжээх цаг ирнэ вий.

Хурандаа ямар нэг юм бодолхийлж ханын шүүгээнээс зузаан даавуун өмдөө хайж гарав.

-Одоо ч хэдхэн сар үлдлээ. Нэгдүгээр сард тулаан болно гэдэг тодорхой. Үүний дараа ч бид түүнийг илүү өндөр үнээр зарж чадна гэж тэр өөртөө хэлэв. Өмд нь авахын аргагүй үнгэгджээ. Эхнэр нь өмдийг авч ширмэн индүүгээр индүүдэж гарав.

-Гадагшаа явах ямар хэрэг гараа вэ?

-Шуудан орохоос...

-Өнөөдөр баасан гариг гэдгийг бүр мартчихаж гэсээр түүнийг өрөө рүүгээ ороод эргэж ирэхэд хурандаа өмднөөсөө бусдыг өмсчихсөн зогсож байлаа. Эхнэр нь нөхрийнхөө гутлыг харснаа:

-Наадахыг чинь хаях цаг болчихож дээ. Түүний оронд чийдсэн гутлаа өмсөхгүй яагаав гэхэд,

-Тэр гутал чинь нэг л эвгүй санагдаад байдаг юм. Түүнийг өмсөх бүрийд би өөрийгөө асрамжийн газраас зугтаж яваа хүн шиг санадаг юм гэж хурандаа бухимдав.

-Хүү минь өнгөрснөөс хойш бүх юм л эвгүйтсэн шүү ДЭЭ...

Хурандаа усан онгоцны дуу сонсдохоос өмнө боомт руу явахдаа чийдсэн гутал, цагаан саарал өмд, захгүй цамцаа өмссөн байлаа. Сири үндэстэн Моисейн дэлгүүрт ороод усан онгоц ирж байгааг ажиглаж зогслоо. Найман цагийн турш нэгэн суудал дээр хөдөлгөөнгүй суусандаа ядарч цөхөрсөн зорчигчид эрэг дээр бууж байлаа. Тэдний дунд долоо хоногийн өмнө явсан тэнэмэл наймаачид, хотын таних, танихгүй оршин суугчид байвч түүнд сонин биш байв. Хамгийн сүүлд шуудангийн усан онгоц ирж харагдав. Арван таван жилийн турш хурандаагийн хүлээлт, горьдлого бөхөөгүй хэдий ч азарган тахиа айдсыг нь нэмэгдүүлжээ. Шуудан зөөгч шуудайтай захидлыг үүрсээр усан онгоцноос буухад хурандаа түүнээс харц салгалгүй ширтэн араас нь дагаж олон арван барааны лангуу, дэлгүүрийн хажуугаар явсаар байлаа. Шуудан зөөгчийн араас явах бүрийд л ямар нэгэн айдаст автаж, зүрх нь хүчтэй дэлсэнэ. Шууданд оруут хэвлэл авахаар хүлээж зогссон эмчийг олж харав.

-Эмч ээ, таныг манайд ирэхдээ буцалсан усаар гарыг тань түлчихээгүй биз гэдгийг эхнэр асуулгаж байна лээ...

Эмч бол толийсон долгиолог үстэй нэгэн билээ. Тэрбээр эхнэрийнх нь биеийн байдлыг лавлахад хурандаа шуудан зөөгчөөс харц салгалгүйгээр эхнэрийнхээ тухай тодорхой ярих. Эмч өөрт ирсэн захидал болон хэдэн сониныг аваад захидлуудыг нүдээрээ гүйлгэн уншив. Энэ үед шуудан зөөгч ирсэн шууданг ялгаж байлаа. Хурандаа хайрцгийн зүг харав. Захаараа цэнхэр хүрээтэй “Авиа” гэсэн бичээс бүхий захидал түүний сэтгэлийг улам гэгэлзүүлэв. Эмч хархүүг хуулиатай сонинг задалж сүүлийн үеийн мэдээллийг унших зуурт хурандаа шуудан зөөгчийгхэзээ түүний дэргэд ирэх бол гэдгийг хүлээн тэсч ядна. Гэвч ийм явдал болсонгүй. Эмч сонин уншихаа больж хурандаагийн зүг ширтэн, дараа нь шуудан зөөгч рүү харснаа дахин хурандаа руу харц чулуудаад,

-Бид явлаа шүү гэж хэлвэл шуудан зөөгч толгой өндийлгөн:

-Хурандаад юу ч алга даа гэлээ.

Хурандаагийн дотор харанхуйлахад,

-Би юу ч хүлээгээгүй гэж тэр худал хэлэв. Тэрбээр хүүхдийн гэнэн харцаар эмч рүү харснаа:

-Надад захиа бичих хүн байхгүй ээ гэв.

Буцах замд тэдний хэн нь ч дуугарсангүй. Эмч сонингоо уншаар алхана. Харин хурандаа алдсан зоосоо хайж буй мэт араас нь гэлдэрнэ. Тэнгэрийн хаяа ягаарсан сайхан үдэш болжээ. Буйлсан моддын шарласан сүүлчийн навчис хаялна. Бүрэнхий болохүед тэд эмнэлгийн үүдэнд иржээ.

-Сонин хачин юу байна даа? гэж хурандаа асуув. Эмч түүнд хэдэн сонин өгөв.

-Мэдэхгүй юм даа. Энэ их хараа хяналт, дарамтан дор хэвлэгдсэн сониноос ямар ч сонин юмаа унших юм билээ дээ.

Хурандаа сонин гарчиглав. Олон улсын мэдээ, дээр нь Суэцийн сувгийг улсын өмч болгох тухай нийтлэл хэвлэгджээ. Тэргүүн нүүр нь бараг тэр чигээрээ эмгэнэл илэрхийлсэн мэдээллээр дүүрэн байв.

-Сонголт хийх ямар ч боломж алга юм чинь яах юм бэ?

-Та ийм гэнэн байж болохгүй ээ, хурандаа. Бид ямар нэгэн үлгэрт итгэхээргүй том болсон хүмүүс шүү дээ.

Хурандаа түүнд сонинуудыг буцааж өгөх гэсэн боловч эмч,

-Та ав, ав. Өнөө орой уншчихаад маргааш өглөө буцаагаад өгнө биз гэв.

Найман цагийн эхээр цамхагийн орой дахь хонх хангиналаа. Анхель ламтан сар бүр шуудангаар авсан шинэ киноны тухай мэдээллийг иймэрхүү байдлаар хүргэдэг билээ. Хурандаагийн эхнэр 12 удаа хонх цохихыг тоолжээ.

-Ямар ч хэрэггүй л юм байх шиг байна. Сүүлийн нэг жил хэнд ч хэрэггүй кино гарах болж. Хорвоо ертөнц ч нүгэлдээ авгжээ гэсээр тэр барьж байсан шалны алчуураа газар шидлээ.

Хурандаад авгайнх нь яриа сонин биш байсан тул хайхарсан ч үгүй. Унтахаасаа өмнө тэр орныхоо хөлд тахиагаа уяж аваад үүдний хаалгыг хааж, хортон шавьжнаас хамгаалах шингэнийг унтлагын өрөөндөө цацав. Дараа нь дэнлүүг шалан дээр тавьж дүүжин ороо өлгөөд сонингоо уншихаар хэвтэв. Сонин гарчиглахдаа тэрбээр он сар, хугацааг няхуур баримтлахаас гадна эхнээс нь аваад сүүлчийн хуудас хүртэл, тэр ч бүү хэл зарлалыг ч орхилгүй уншдаг зуршлаа ч энэ удаа бас дагав.

Шөнийн 11 цагт бишгүүр дуугарч сонстох нь комендатын цаг эхэлсний дохио ажээ. Хагас цагийн дараа хурандаа сонинуудаа уншиж дуусгаад гаднах хаалгаа онгойлгон бөөн шумуул довтлох гүн харанхуйд гарч “морь харав”. Түүнийг эргэн орж ирэхэд эхнэр нь унтаагүй байлаа.

-Ахмад зүтгэлтнүүдийн тухай юу ч бичээгүй байна уу?

-Юу ч алга гэж хурандаа хэлээд дэнгийн гэрлээ унтрааж дүүжин оронд хэвтсэнээ:

-Урьд өмнө ядаж тэтгэврийн хөгшчүүдийн нэрсийг хэвлэдэг байсансан. Гэтэл сүүлийн таван жил бичихээ ер больчихож гэв. Тэр их л харамсаж байвч санаа алдах гэгчийг мартаад нэн уджээ.

Шөнө дөлөөр ахиад л бороо орж эхэллээ. Хурандаа унтсан боловч гэдэс нь хүчтэй базласны улмаас төдөлгүй сэрэв. Гэрийн хаа нэгтээ усны дусаал гоожих чимээ сонстоход хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрсөн боловч яг хаахна дусал гоожиж буйг тодорхойлохыг оролдов. Хүйтэн хөлс нурууг нь даган урсажбайлаа. Тэр халуурчээ. Ямар нэг намганд сэлж байгаа шиг санагдах ба хэн нэгэн түүнтэй ярих мэт. Хурандаа дүүжин орон дээр хэвтэнгээ ярьж эхлэхэд нь,

-Чи хэнтэй яриад байна аа? гэж эхнэр нь асуув.

-Аурелиано Буэндиа хурандаагийн хуаранд ирсэн барсын арьс нөмөрсөн англи эртэй л ярьж байна... Түүнийг Мальборо бэйс гэдэг байлаа.

Хурандаа үүр цайхын алдад сэрэхдээ хэзээ ч өөрийгөө ийм муу байсныг санахгүй байв. Хонхон дуу хоёронтаа сонстоход тэрбээр дүүжин орноос өндийж азарган тахианы түгшсэн дууг сонсов. Нүднийх нь өмнө гарт үл баригдах цагирагууд хөвнө. Түүний дотор эвгүйрхжээ. Тэрбээр гадагш гарч жорлон руу зүглэв. Цайран хаалгатай модон жорлондорвол шивтэр хийгээд ялгадсын сэнхийсэн үнэр угтлаа. Хурандааг хаалга онгойлгомогц бөөн хар ялаа урдаас нь дүнгэнэлдэн нислээ. Хүлээлт нь ямар ч үр дүнгүй болжээ. Харуулдаж засаагүй банзан гишгүүр дээр хагас суун тавлахыг хичээвч түүний зовлонт хүсэл биелэх хувьгүй байжээ. Гэвч гэдэсний өвдөлт нь ер зүгээр болсонгүй.

-Хачин юм, аравдугаар сард дандаа л ингэх юм хэмээн тэрбээр амандаа бувтнаад гэдсэн дэх мөөгнүүдээ тайвшруулахын тулд маш их тэвчээр гарган нэлээд удаан суусны эцэст гарч азарган тахиагаа авахаар явав.

-Чи шөнө дэмийрч байсан шүү гэж эхнэр нь хэллээ. Хурандаа юу болсныг санахыг оролдоод,

-Би яаснаа мэдэхгүй юм, гэхдээ зүүдэндээ дахин аалзны тор харсан шүү...

Урьдын адилаар хууч нь хөдлөснийхөө дараа эхнэр нь маш их уур уцаартай болдог байлаа. Үд болтол тэрээр гэрийн бүх эд юмсыг онгичиж амжсан төдийгүй цаг болон ханын зургаас бусад зүйлийн байрыг солихыг сольж, энд тэнд өлгөхийг нь өлгөжээ. Туранхай

жигжигхэн биетэй, гавшгай шалмаг хөдөлгөөнтэй эзэгтэйг гэр дотуур зөөлөн шаахай углаж хар даашинзаа өмсөн явахыг нь харах үед бараг л хана нэвглэх чадвар эзэмшсэн мэт санагдана. Гэвч үдээс хойш тэрээр бодит амьдралдаа эргэн ирдэг билээ. Харин орондоо хэвтүүт байгаа байхгүй нь үл мэдэгдэнэ. Эдүгээ түүнийг энд тэнд цэцэг навчтай зууралдан нааш цааш холхихыг нь харахуйд бараг л гэр дүүрэн мэт харагдана.

-Агустиныг нас барснаас хойш ядахдаа нэг жил өнгөрсөн бол би дуулахсан гэж тэрээр хэлээд энэ ертөнцийн хөрсөн дээр ургадаг идэж болох ямар л үр, ногоо байна тэдгээрийг жижиглэн хэрчээд саванд чанаж байлаа.

-Хэрэв чи дуулмаар бол дуул л даа. Дуулах чинь цөсөнд сайн юм гэдэг.

Хурандааг эхнэрийн хамт гал зууханд кофе ууж суухад гаднах хаалга онгойж:

-Үхпээ хүлээгсэд энд амьдардаг уу? гэсээр эмч хархүү орж ирэв.

-Тийм байж магадгүй, эмч ээ гэсээр хурандаа түүнийг угтан бослоо.

-Таны цагямар ч хэрэггүй болсон. Үргэлж л түрүүлж явах юм гэж би хэлдэг байсан шүү.

Эхнэр нь үзлэгт бэлтгэхээр унтлагын өрөө рүүгээ ороход эмч хурандаагийн хамт зочны өрөөнд үлдсэн хойноо түүнд нэгэн дугтайтай зүйлийг өгч,

-Өчигдрийн сонинуудад бичигдээгүй зүйл энд байгаа гэж хэлээд унтлагын өрөө рүү явав. Хурандаагийн бодож байснаар дугтуйнд хууль бусаар тараахад зориулан хэвлэсэн, улс оронд болж буй сүүлийн үеийн үйл явдлын тухай мэдээнүүд байлаа. Тэдгээр мэдээлэлд алслагдсан дүүргүүдэд зэвсэгт тэмцэл өрнөж буй тухай өгүүлжээ. Хууль бус уран зохиол арван жил уншсан ч хамгийн сонирхолтой мэдээ үргэлжурд минь байх болно гэдэгт тэрбээр одоо болтол суралцаагүй байв. Эмчийг зочны өрөөнд орж ирэхэд тэр нэгэнт уншиж амжсан байлаа.

-Энэ өвчтөн надаас илүү наслана гэдэгт мөрий тавьсан ч болно. Иймэрхүү багтраатай хүн дахиад зуу ч насалж магадгүй...

Хурандаа түүнийг гунигтайгаар ширтээд эмчид дугтуйг дуугүйхэн сарвайвал тэр авахаас татгалзаж, -Бусад хүмүүст ч гэсэн уншуул л даа гэж хэлэв. Хурандаа дугтуйг өмднийхөө халаасанд нуулаа. Энэ үеэр эхнэр нь унтлагын өрөөнөөс гарч ирээд:

-Нэгэн сайхан нартай өдөр би үхэж тамд одохдоо таныг авч явахаа мартажгүй шүү, эмч ээ гэвэл эмч нүд гялбам цагаан шүдээ яралзуулан жуумалзав. Дараа нь тэр ширээний дэргэдэх сандлыг татан авч суугаад цүнхнээсээ шинэ эмийн сурталчилгааны хэдэн загварыг гаргахад эзэгтэй гал зуух руу явангаа,

-Хүлээзнээрэй, би танд кофе халааж өгье гэвэл, -Баярлалаа, зүгээр. Намайг хорлох гэсэн бүх боломжийг би тас хаадаг юм гээд жор бичиж байхдаа инээмсэглэв.

Бичиж дуусмагцаа эмч түүний бичгийн хэвийг гаргаж чадахгүй гэж бодсон уу, яасан эмийн жорыг уншиж өгөв. Хурандаа анхааралтай сонсохыг хичээнэ. Эхнэр нь зочны өрөөнд эргэж ирээд өнгөрсөн шөнийн өвчний зовиур түүнд өөрийн гэсэн ул мөрөө үлдээсэн болохыг анзаарчээ.

-Өнөө өглөө үүрээр манай хүн нэлээд халуурлаа. Бараг л хоёр цаг иргэний дайны тухай дэмийрсэн шүү гэвэл хурандаа зогтусав

Хурандаа зогтусав.

-Би дэмийрээгүй ээ гэж хэлээд өөрийгөө удирдах чадвараа алдаагүй гэдгийг харуулах мэт бардамханаар -Урьд шөнө миний бие үнэхээр эвгүй байсан боловч би ямар ч хүнд найдлага тавиагүй, тавих ч үгүй. Би өөрөө өөрийгөө хог дээр аваачаад хаячихаж чаднаа гээд эмчээс авсан хэвлэлийг авчрахаар унтлагын өрөө рүү орлоо.

-Цэцэг өгсөнд тань баярлалаа гэж эмч хэлэв. Тэд цугтаа гарч талбайн тийш зүглэв. Агаар нэн хуурай байлаа. Цардмал зам хэт их халуунаас болж хайлж буй мэт санагдана. Эмчийг салах ёс гүйцэтгэх үед хурандаа шүдээ зуунгаа:

-Эмч ээ, бид танд хэдийг төлөх вэ? гэж аяархан асуув.

-Одоохондоо хэрэггүй. Гэхдээ би азарган тахиаг чинь ялалт байгуулсан цагт танд овоохон төлбөр тавина даа гээд мөрийг нь алгадав.

Хурандаа тэндээс Агустины найз нарт хууль бус мэдээллийг дамжуулахаар гутал засварын газрыг зүглэжээ. Энэхүү гуталчны газар түүний намын хамтран зүтгэгч нар үхэж үрэгдэж, хотоос цөлөгдөх нь цөлөгдөхөд баасан гариг бүр шуудан хүлээхээс өөр ямар ч санаа зовох зүйлгүй хүн шиг болж хувирсан тэр цагаас хойш түүний очих болсон цорын ганц газар нь болжээ.

Өдрийн халуун эхнэрийнх нь идэвхийг улам сэргээж тэрээр гэрийнхээ саравчинд тарьсан цэцэгсийн дунд бүртэгнэх агаад түүний дэргэд хуучин хувцастай хайрцаг харагдана. Тэр үргэлж л юмхнаар юм хийж өөрийнхөө хувьд мөнхийн гайхамшгийг бүтээдэг байлаа. Бас цамцны ханцуйгаар зах хийж олон өнгийн өөдсөөр дөрвөлжин алчуур ч урлана.

Нар хэвийжээ. Гэвч тэрээр цэцэгсийн дунд шингэх нарны илчийг үл анзаарна. Хурандааг ирэх үед тэрээр дуртай ажлаа орхиод:

-Тархи толгой бүр гашилчихаж гэв.

-Үргэлж л тийм байсан биз дээ? гэж хурандаа хэлснээ өнгө өнгийн өөдсөн алчуураар өөрийгөө ороосон эхнэрийгээ хараад:

-Чи яг л тоншуул шиг харагдаж байна шүү гэжээ. -Энэ бүхнээс ямар нэгэн хувцас урлахын тулд тоншуул ч болж магадгүй шүү.

-Багт наадам дээр чи зөвхөн хүрмээ тайлахад л болно гэсээр тэр гурван өнгийн даавуу

зүйж оёсон цамцыг эвхэж тавилаа. Түүний яриаг хонхон дуу таслахад тэрээр бурхандаа залбирсаар унтлагын өрөө рүүгээ зүглэв.

Хурандаа сургуулиас ирэх замдаа азарган тахиаг нь харахыг хүссэн хүүхдүүдтэй хэсэг суув. Дараа нь тэр маргааш өгөх эрдэнэ шиш байхгүй шүү дээ гэж санан эхнэрээсээ мөнгө гуйхаар унтлагын өрөө рүүгээ орлоо.

-Манайд ердөө тавин сентаво л үлдсэн байх даа...

Тэрээр мөнгөө хамрын алчуурт боож орны гудсан доороо хадгалдаг байв. Энэ мөнгө бол Агустин хүүгийнхээ оёдлын машиныг зарсны төлбөр ажээ. Сүүлийн есөн сарын турш тэд өөрийн болон тахианыхаа хэрэгцээнд зориулж бага багаар энэ мөнгийг зарцуулсан боловч одоо тэнд аравтын нэг, мөн хоёрхон ширхэг хорьтын зоосон сентаво л үлджээ.

-Нэг фунт эрдэнэ шиш аваарай. Харин үлдсэн мөнгөөр нь маргааш уух кофе, дөрвөн унци бяслаг авчихаарай гэж эхнэр нь хэлэв.

-Ер нь үүдэндээ алтадсан заан авсан нь дээргүй юу? Ганц эрдэнэ шиш гэхэд л дөчин хоёр сентаво шүү дээ гэж хурандаа гэнэт уурсаад бодолд бас л автлаа.

-Азарган тахиа бол хүн биш, амьтан. Тэр тэсвэрлэж чадна гэж эхнэр нь тээр хойно ам нээв.

Гэсэн хэдий ч хурандаагийн царай төрх түүнийг дуугүй байхад хүргэсэн учир өвдгөө тохойлдон орон дээр суухдаа гарт атгасан зоосоо хооронд нь хавирч байлаа.

-Би өөрийнхөө тухай бодоогүй юм шүү. Хэрэв би амиа бодсон бол өнөөдөр ч гэсэн түүгээр шөл хийгээд уучихаж болно. Тавин песогоор ходоодоо хямруулах гэдэг мэдээж сайхан л байж таараа гээд мөн л дуугаа хураав. Хурандаа юу ч дуугаралгүй суух агаад хүзүүн дээр суусан шумуулыг алгадангаа өрөөн дотуур алхах эхнэрээ харж суулаа.

-Би хүүхдүүдийн тухай бодож байна. Тэд мөнгөө цуглуулаад эхэлчихсэн шүү дээ...

Энэ удаа түүний эхнэр бодолд автжээ. Тэрээр өрөөн дотуур явж хана туурга руу шумуулын эсрэг шингэн цацна. Эхнэр нь гэрт хоргодсон сүнсүүдийг зөвлөгөөнд дуудаж буй мэт үзэгдэх ажээ.

-Эрдэнэ шиш аваарай. Биднийг цааш хэрхэхийг ганцхан бурхан л мэдэх хэрэг.

Түүний эхнэр ямар нэгэн аргаар, юугаар ч юм хоол хийх гайхамшигтай ур чадвараар бусдаас ялгардаг хүн. Аравдугаар сар амархан дуусахыг хүссэнгүй. Нарны зэс туяанд баярласан эхнэр нь гурван үдшийн турш үсээ арчлав.

-За, ингээд л ёслолын алба эхэлж байна даа гэж эхнэрийгээ урт буурал үсээ шүд нь унасан самаар самнах үед хурандаа ёжлов.

Маргааш өдөр нь тэрээр хөл доороо цагаан даавуу дэвсэн саравчинд суугаад өвчтэй

байх үедээ үржсэн бөөсийг үснээсээ түүж цаг нөхцөөв.

Гурав дахь өдөр нь тэрээр тусгайлан бэлтгэсэн усаар толгойгоо угааж, үсээ хатаасны дараа хоёр хэсэг сүлжив. Энэ хугацаанд хурандаа зүгээр л хүлээн сууж байлаа. Үдшийн бүрийд дүүжин орон дээр нойр нь хүрэхгүй хөрвөх үедээ тэрбээр гагцхүү азарган тахианы тухай л бодолд автана.

Лхагва гаригт түүнийг жинлэж үзэхэд хэвийн хэмжээнд байв. Агустины найз нар гэр гэртээ харихдаа ялалт бидний халаасанд байна гэж хөгжин наргихад хурандаа ч гэсэн даган баясав. Эхнэр нь түүний үсийг засчээ.

-Чи намайг хорин насаар залуужуулчихпаа гэсээр өвгөн толгойгоо илэв.

-Миний бие гайгүй бол үхсэн хүнийг ч би амилуулж чадна л даа гэж эхнэр нь хэлсэн боловч тэдний сэтгэлийн хөөрөл удаан үргэлжилсэнгүй. Цаг хийгээд ханын зургаас өөр зарах юм гэрт үлдээгүй ажээ. Пүрэв гаригийн орой хоол хүнсний сүүлчийн нөөц дуусмагц эхнэр нь санаа зовж эхлэв.

-Чи битгий санаагаар уна л даа. Маргааш шуудан ирнэ гэжхурандаа түүнийг тайвшруулжхэлсэн ч өөртөө итгэхгүй байлаа.

Өглөө нь тэр эмнэлгийн үүдэнд зогсож усан онгоц ирэхийг хүлээлээ.

-Нисэх онгоц гэдэг гайхамшигтай эд шүү. Ганцхан шөнийн дотор Европт хүрч болдог юм гэнэ билээ гэсээр шуудангийн уутнаас харц салгалгүйгээр хурандаа хэлэв.

-Магадгүй шүү гэж зурагт сэтгүүлээ дэвүүр мэт сэвэнгээ эмч хариу барив. Энэ үед хурандаа шуудан зөөгчийг олон хүний дундаас олж харлаа. Эхлээд шуудан зөөгч бууж ирэв. Тэрбээр ахмадаас лацадсан дугтуйг аваад онгоцны тавцан дээр гарч шуудангийн уутыг торхтой шатахууны дэргэд тавьжээ.

-Энэ ч осолтой байж магадгүй юм гэж хурандаа бодов. Тэрбээр шуудан зөөгчийг олон өнгийн ундааны шилтэй тэргэнцрийн дэргэдээс олж харлаа.

-Хүн төрөлхтөн хөгжлийн төлөө үргэлж төлөөс төлдөг.

-Уг чанартаа нисэх онгоц гэдэг усан онгоцноос аюулгүй эд шүү дээ. Хорин мянган футын /тохой/ өндөр дээр ямар ч далайн шуурга хүрэхгүй гээч гэж эмч тайлбарлав.

-Хорин мянган фут гэнэ ээ? хэмээн тийм өндөр дээр нисч болохыг ер төсөөлж үзээгүйдээ балмагдсан хурандааг давган хэлэхэд эмч сэдвийг улам өргөжүүлэхээр шийдэж, хоёр гараа алдлан алган дээрээ нээлттэй сэтгүүлийг тавьж ямар ч хөдөлгөөнгүй зогслоо.

-Мэдээж хэрэг агаарт туйлын тогтвортой байдалд байна гэсэн үг л дээ гэж тэр хэлэв.

Гэвч хурандаагийн анхаарал аль хэдийнээ шуудан зөөгч дээр төвлөрч солгой гартаа шилэн аягатай жимсний ундаа барин ууж байгааг харав. Баруун гартаа шууданч уутаа

барьжээ.

-Үүнээс гадна далайд шөнийн нислэг үйлддэг онгоцтой байнгын холбоотой байдагусан онгоцууд ч бас зогсдог юм. Иймэрхүү урьдчилан сэргийлэх байдалтай онгоц нь усан онгоцоосхавьгүй илүү найдвартай байдаг гэхэд хурандаа түүн рүү харан,

-Онгоцууд яг л нисдэг хивсэн дээр аялж байгаа мэт байдаг биз гэж хачирлав.

Шуудан зөөгч тэдний зүг ирж буйг хараад хурандаа өөрийн мэдэлгүй арагш ухран түгшүүрт автан дугтуйтай захидал хэнд ирсэн болохыг таахыг оролдож байлаа. Шуудан зөөгч уутыг задлан эмчид багц сонин гаргаж өгөв. Дараа нь хувийн захидлуудтай боодлыг задалж тэдгээрийн тоог тасалбартай тулгаж, хаягласан хүмүүсийн нэрсийг уншиж эхлэх үед эмч амандаа:

-Дахиад л Суэцийн суваг... Өрнөдийнхөн доороо гишгэх газаргүй болж байх шив гэж үглэлээ. Хурандаад сонин үзэх сөхөө байсангүй агаад гэдэснийхээ хүчтэй базлалтыг тэсвэрлэн зогслоо.

-Хяналт хийдэг болсноос хойш энэ сонинууд дээр Өрнөдийн тухай л бичдэг болоо шив дээ. Европчууд наашаа ирж, бид тийшээ шилжин суурьшвал таарна. Тэгвэл хүн бүр эх оронд нь юу болж байгааг мэддэг болох байлгүй.

-Европчууд Хойд Америкийг амандаа сахалтай, гартаа гитар, буу, зэвсэг агссан эрчүүдээр төсөөлдөг. Тэд бидний байдлыг хэзээ ч ойлгохгүй дээ гэсээр эмч инээд алдав. Шуудан зөөгч түүнд захидал өгөөд үлдсэнийг нь уутанд хийж амыг боов. Эмч авсан захидлуудаа уншихаар дугтуйг задлахыг завдсанаа больж эхпээд хурандааг, дараа нь шуудан зөөгч рүү харлаа.

-Хурандаад юу ч алга уу?

Хурандаагийн дотор эвгүйрхэв. Шуудан зөөгч ууттай захидлаа нуруундаа үүрч хэдэн алхам холдсоноо эргэж харалгүйгээр:

-Хурандаад захидал бичсэн хүн алга байна гэлээ.

Урьдын тогтсон зуршлаар хурандаа шуудхан гэр рүүгээхарьсангүй, гутал засварын газарточижАгустины найз нарыг сонин унших зуур кофе ууж суулаа. Тэрбээр өөрийгөө хууртагдсан мэт санав. Өнөө орой тэр эхнэртээ хоосон очихгүйн тулд энд ирэх долоо хоногийн баасан гариг хүртэл суусан ч чадахаар байлаа. Гэвч засварын газар хаахад үнэнээс хаашаа ч зайлахгүй гэдэгтэй нэгэнт эвлэрчээ. Эхнэр нь түүнийг хүлээж байлаа.

-Юу ч алга уу? гэж түүнийг асуухад,

-Юу ч алга гэж хариулав.

Ирэх долоо хоногийн баасан гаригт дахиад л шуудангийн онгоцыг тосов. Урьд өмнөх баасан гаригуудын адил энэ удаа хаанаас ч юм ирэх ёстой захидлыг удаан хүлээсэн ч үгүй гар

хоосон гэртээ ирлээ.

-Бид хүлээхээрээ л нэг боллоо. Арван таван жил захидал хүлээнэ гэдэг ёстой л бух шиг тэвчээр заах хугацаа юм даа гэж эхнэр нь тэр орой хэлжээ. Хурандаа дүүжин орондоо хэвгэн дадсанаараа сонин уншиж эхлэв.

-Өөрийн дарааллыг хүлээх хэрэгтэй. Манай дугаар мянга найман зуун хорин гурав биз дээ?

-Тэгвэл бидний хүлээсэн цагаас хойш энэ дугаар хоёр удаа сугалаанд таарч байна гэж эхнэр нь хариуллаа.

Хурандаа урьдынхаараа бүх сонины хуудас бүрийг, тэр ч бүү хэл зарлал сэлтийг хүртэл алгасалгүй уншив. Гэхдээ энэ удаа нэг их шимтэж үзсэнгүй. Гэвч цаг ямагт ахмад зүтгэлтнийхээ тэтгэврийн тухай бодож байлаа. Арван есөн жилийн өмнө Их хурал тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг баталсан бөгөөд цагаатгалын ажиллагаа үүнээс хойш найман жил сунжирч билээ. Дараа нь тэтгэврийнхний нэрсийг тогтоох гэсээр зургаан жил болов. Энэ тухай хурандаагийн авсан сүүлчийн захидалд тэгэж дурьдсан байж билээ.

Комендантын цаг дууссаны дараахан хурандаа сонинуудаа хойш тавьж, гэрлээ унтраах гэсэн авч эхнэрээ унтаагүй болохыг анзаарав.

-Чамд өнөө сонингийн хайчилбар байгаа юу?

Эхнэр нь тэр даруй хариулсангүй.

-Бусад бичиг баримттай л хамт байгаа байлгүй дээ.

Тэрээр орноос өндийж ханын шүүгээнээс жижигхэн модон хайрцаг гаргаж ирэв. Захидлуудыг ирсэн дарааллын дагуу нэгтгэж резинээр боосон байлаа.

Тэнд цэргийн тэтгэврийг авахад идэвхтэй нөлөө үзүүлэхээ амласан өмгөөллийн товчооны зарлал ч бас байх ажээ.

-Чамд өмгөөлөгчөө соль гэж үглэсэн тэр цагаас хойш хичнээн ч жил өнгөрөв дөө. Энэ хугацаанд бид мөнгөө аваад зогсохгүй түүнийгээ үрж зарцуулах ч боломж зөндөө л байлаа гэсээр нөхөртөө сонингийн хайчилбарыг өгөв.

-Индианчуудын адил биднийг үхсэн хойно мөнгийг маань авсанд хийвэл ямар л олиг байх вэ дээ.

Хурандаа хоёр жилийн өмнөх сонины нийтлэлийг эргэн нэг уншсанаа түүнийг авч хаалганд өлгөөтэй байсан цамцныхаа халаасанд хийв.

-Өмгөөлөгчөө солихын тулд мөнгө хэрэгтэй бол ч хэцүүдэх байх даа.

-Одоохондоо гайгүй биз дээ. Бидэнд олгох ёстой тэтгэврийн мөнгөнөөс л суутгаж

аваарай гээд л биччихье. Тэдний сонирхлыг ч татаж юуны магад.

Бямбад хурандаа өөрийн өмгөөлөгчтэй уулзахаар очвол тэр нөхөр дүүжин орондоо тайван хэвтэж байлаа. Тэр бол зөвхөн үүдэн хоёроос өөр шүдгүй, нэлээд биерхүү хар арьстан аж.

Өмгөөлөгч модон ултай шаахайгаа углаад өрөөний цонхыгнээв. Цонхны дэргэд тоосонд дарагдсан төгөлдөр хуур байх агаад дээр нь хэрэгтэй хэрэггүй бичиг цаас овоолоостой байлаа. Татварын албанаас ирүүлсэн зүсэн зүйлийн мэдэгдлийн цуглуулга ч харагдана. Даралтгүй төгөлдөр хуураар бичгийн ширээгээ орлуулсан өмгөөлөгч пүрштэй сандал дээр тухлан суув. Ирсэн учир шалтгаанаа тайлбарлахаас өмнө хурандаа нөхцөл байдалд ихэд санаа зовж буйгаа илэрхийлвэл:

-Би танд анхааруулж байсан. Иймэрхүү ажлыг нэг өдөрт багтааж хийнэ гэж байхгүй шүү дээ гэж өмгөөлөгч айлдав. Халууцсанаасаа болж бие нь ихэд нозоорсон харагдах тэрбээр сандлынхаа түшлэгийг налж гэдийгээ сурталчилгааны төсөл бичсэн цаасаар өөрийгөө сэвж суулаа.

-Би үргэлж өөрийн итгэсэн хүмүүстэй холбоо барьж байгаа. Тэд ч надад санаа зоволтгүй гэж зөвлөж байна лээ.

-Ингэсээр байгаад арван таван жил өнгөрсөн шүү дээ. Яг л нөгөө цагаан тугалны тухай үлгэрт гардаг шиг л ужиг юм болж байна даа гэж хурандаа хариу баривал өмгөөлөгч хүнд суртлын ажиллагааг нэгд нэгэнгүй тайлбарлаж гарав. Сандал нь түүний шалхгар өгзгөнд дэндүү багаджээ.

Арван таван жилийн өмнө бүх юм арай хялбархан байсанж. Тэр үед хоёр намын төлөөлөгчдөөс бүрдсэн ахмад зүтгэлтнүүдийн орон нутаг дахь холбоо гэж байв. Тэрбээр бүгчим агаараас гүнзгий амьсгалаад, дөнгөж сая өөрөө зохиосон мэт:

-Эв нэгдэлд хамаг хүч оршино гэж дуугарав.

-Энэ бол надад хамаатай зүйл биш. Миний найз нөхөд тэтгэврээ хүлээсээр байгаад нас барцгаасан гэж хурандаа өөрийн ганцаардлыг ухаарсан мэт бодож явдгаа уудлавал өмгөөлөгч ер тоосонгүй.

-Хуулийг маш хожуу баталсан. Тэгээд ч таны адил хорин насандаа хурандаа болсон хүн олон байхгүй шүү дээ. Засгийн газар төсвөөс мөнгө хумсалж энэ асуудлыг шийдэхээс өөр аргагүйд хүрчихээд байна гэв.

Яг л нэгэн ижил түүх. Түүний яриаг сонсох бүрийд хурандаа битүүхэндээ бачимддаг байлаа.

-Би гуйлга гуйгаагүй шүү. Тэгээд ч бидэнд ямар нэгэн ач тус хүргэх тухай юм яриагүй. Бид Бүгд Найрамдах Улсаа хамгаалахын тулд амь биеэрээ дэнчин тавин тэмцэж байсан юм шүү...

Өмгөөлөгч энэ бүхнийг дахин үл хайхрав.

-Энэ бол яг л тийм шүү, хурандаа. Хүмүүс ч тэгээд тусыг усаар л хариулдаг боллоо доо...

Энэ үгийг ч гэсэн хурандаа нэг бус удаа сонсож байлаа. Анх иймэрхүү үгийг Неерландын баримт бичгийг баталсны маргааш нь сонсч байсан бөгөөд тэр үед засгийн газарт 200 офицерт хохирлыг нөхөн төлж, гэрт нь буцаах тухай амлаж байсан билээ. Неерландад тэд гол төлөв сургуулиа орхисон өсвөр үеийнхнээс бүрдсэн хувьсгалч батальоноо хэд хэдэн хэсэг болгон буудаллаж гурван сарын нүүрийг үзжээ. Дараа нь тэд яаж ийгээд гэр гэртээ харьцгаасан агаад гэртээ очоод үхлээ хүлээх болсон юм. Тэр цагаас хойш бараг жаран жил өнгөрсөн авч хурандаа хүлээсээр л байгаа нь энэ. Дурсамжинд сэтгэл нь хөдөлсөн хурандаа хойш гэдийж баруун гараараа хэрзгэр ташаандаа гараа тулснаа “Яс, арьс л болоо шив дээ” гэж дотроо бувтнав.

-За, би сонголтоо хийе, ноён өмгөөлөгч өө!

-Юу гэсэн үг вэ? хэмээн өмгөөлөгч болгоомжлов.

-Би өмгөөлөгчөө сольж байна гэдгээ л хэлж байгаа юм.

Тасалгаанд араасаа хэдэн шар дэгдээхэй дагуулсан нугас орж ирвэл өмгөөлөгч хагас өндийж тэднийг хөөхийг завдаад,

-За, хурандаа. Таны л мэдэх хэрэг шүү дээ. Таны хэлснээр л болог. Хэрэв би ид шидийг бүтээж чаддаг байсан бол энэ нохойн хуаранд юу гэж амьдрах вэ дээ? гэсээр шувуудыг тасалгаанаас гаргав. Тэрбээр саравч руу орох үүдийг төмөр хайсаар хашаад сандалдаа эргэн суув.

-Миний хүү бүх амьдралынхаа турш ажил эрхэлж байсан. Манай байшин барьцаанд байдаг. Гэтэл тэтгэврийн тухай хууль гагцхүү өмгөөлөгчдийн амьдрал ахуйг бүх насаар нь тэтгэх завшаан болон хувирч л дээ...

-Миний хувьд л лав тийм биш шүү. Би сүүлчийн сентавог хүртэл шүүхийн ажиллагаанд зарцуулсан хүн гэж өмгөөлөгч өөрийгөө өмөөрөв. Хурандаа гэнэт гаргасан цочмог зангаасаа ичих шиг болсон тул,

-Би үүнийг л хэлэхийг хүссэн юм. Энэ халуунаас чинь болж тархи толгой хүртэл зэвэрч гүйцлээ гэсээр цамцныхаа ханцуйгаар духныхаа хөлсийг арчив. Өмгөөлөгч тэр даруй гэрээний эрэлд гарч, байдаг юмаа онгичиж эхэллээ. Өдрийн наран мужааны харуул ч хүргээгүй банзаар хийсэн өрөвдөлтэй өрөөний голд тусчээ. Ямар ч үр ашиггүй эрэл хайгуулын эцэст өмгөөлөгч дөрөв хөллөн мөлхөж төгөлдөр хуурын доороос нэгэн боодолтой зүйлийг гаргаж ирсэнээ,

-Энэ байна гээд нэг хуудас тэмдэгт цаасыг хурандаад сарвайн:

-Би өөрийн итгэмжлэгдсэн этгээдэд хуулбарыг хүчингүй болгох тухай бичих хэрэгтэй байна гэв. Хурандаа тэрхүү баримтын тоосыг сэгсэрч цамцныхаа халаасанд хийлээ.

-Та түүнийг урж болно шүү дээ гэж өмгөөлөгч хэлвэл,

-Үгүй ээ. Энэ бол миний хорин жилийн дурсамж гэж хурандаа эрсхэн хариуллаа.

Тэрбээр өмгөөлөгчийг бусад баримтыг үргэлжлүүлэн хайна гэдгийг хүлээжээ. Гэвч тэр ахиж бичиг цаас хайсангүй. Харин дүүжин ор луугаа дөхөж очоод хөлсөө шударснаа хурандаагийн зүг харахад нь,

-Надад бусад баримт бичиг ч бас хэрэгтэй байна гэв.

-Ямар бусад баримт?

-Цагаатгалын бичиг.

-Энэ бол бүтэшгүй зүйл шүү дээ, хурандаа гээд өмгөөлөгч гараараа зангав.

Хурандаа түгшиж эхэллээ. Тэрбээр Макондо тойргийн Хувьсгалт армийн сангийн нярав байхдаа урт удаан зургаан хоногийн турш ардын журамт цэргийн хоёр шуудай сангийн хөрөнгийг ачсан бухыг хөтөлж явсан билээ. Тэр Неерландын хуранд хүрэхдээ өлсгөлөнд нэрвэгдэж, үхэхээ дөхсөн бухыг араасаа хөтлөсөөр гэрээнд гарын үсэг зурахаас хагас цагийн өмнө амжиж очжээ. Хурандаа Аурелиано Буэндиа бол Атлантын эрэг хавийн хувьсгалт армийн бэлтгэл генерал хүн агаад түүнд бууж өгсөн тохиолдолд хураалгах эд зүйлсийн дотор тэрхүү хоёр шуудай хөрөнгийг оруулах зөвшөөрлийг олгожээ.

-Тэр баримт бичиг маш их чухал үнэ цэнэтэй зүйл. Сангийн хөрөнгө хүлээж авсан тухай баримт бичигт хурандаа Аурелиано Буэндиа өөрийн биеэр гарын үсэг зурсан юм гэж хурандаа хэлвэл,

-Ойлгож байна. Гэвч тэдгээр баримт бичиг олон мянган хүний гараар дамжиж, олон мянган албан тасалгаагаар орж, гарч, эцэс сүүлд нь цэргийн яамны ямар хэлтэст нь очоод үгүй болсныг ганцхан бурхан л мэднэ байх хэмээн өмгөөлөгч ярив.

-Тийм чухал баримт ямар нэгэн түшмэлийн хувьд үл анзаарам зүйл гэж би бодохгүй байна шүү...

-Гэвч сүүлийн арван таван жилийн дотор түшмэдүүд олон удаа солигдсон шүү дээ. Энэ хугацаанд долоон ерөнхийлөгч солигдож, ерөнхийлөгч бүр арвантаа өөрийн багаа сольж, сайд болгон доод тал нь зуугаас доошгүй удаа өөрийн бүх албатуудыг хольж сольсон тухай та бодож үзсэн үү? гэж өмгөөлөгч санууллаа.

-Гэхдээ тэдний хэн нэг нь арай тэр баримтыг гэр лүүгээ авч яваагүй байлгүй дээ. Шинээр ажилд орсон түшмэл болгон түүнийг нөгөө л газраа байхыг олж харж байсан даа гэж хурандааг өгүүлэхэд өмгөөлөгч цөхрөнгөө барсан янзтай,

-Хэрэв одоо бүх бичиг баримтыг яамнаас эргүүлэн авах хүсэлт тавьбал та нэрсийн жагсаалтанд дахин орохоос өмнө тэр цааснууд чинь бараг л бүх хэлтсээр дамжихаас өөрцгүй болно доо гэжээ.

-Энэ чухал биш ээ.

-Гэхдээ энэ чинь аягүй бол зуун жил ч сунжирч магадгүй.

-Тэр онц биш. Хамгийн гол нь их юм хүлээж байгаа хүн бага зүйлийг хүлээж чаддаг юмаа...

Хурандаа зочны өрөөний ширээн дээр бичгийн цаас, үзэг, бэх хийгээд уудаг цаас тавиад эхнэртэйгээ зөвлөлдөх хэрэг гарч магадгүй хэмээн бодож өрөөний хаалгыг онгорхой орхив. Тэрээр эрхийг эргүүлэн залбирч суулаа.

-Өнөөдөр хэдэн билээ?

-Аравдугаар сарын 27.

Хурандаа их л гаргацтай бичих зуур үзгээ уудаг цаасан дээр тавьж, нуруугаа цэхлэн яг л сургуульд зааж сургасан шиг эгцлэн суулаа. Өрөөнд хэт халуун байснаас болж түүний хөлсний дусал цаасан дээр дуусанд хурандаа түүнийг арчив. Дараа нь цаасанд ууссан үгийг арчих гэсэн боловч завааруулж орхилоо. Гэвч ер гутарсангүй. Цаасны өнцөгт “Бүх эрх хүчин төгөлдөр” гэж бичив. Дараа нь бичсэн зүйлээ эргэн нэг уншиж үзэв.

-Ингэхэд нэрсийн жагсаалтанд намайг хэзээ орууллаа?

Эхнэр нь мөргөл үйлдэх зуураа эргэн санаснаа:

-1949 оны наймдугаар сарын 12-нд гэж хэлэв. Төдөлгүй бас бороо орлоо. Хурандаа Мануар дахь төрийн сургуульд түүнийг бичиж сургасны дагуу хуудсыг хүүхдийн гэмээр том том үсгүүдээр дүүргэжээ. Дараа нь дахин тал хуудас нэмж бичээд гарын үсгээ зурж эхнэртээ захидлыг уншиж өглвөл өгүүлбэр бүрийн дараа толгой дохиж байв. Уншиж дуусмагцаа хурандаа дугтуйг нааж дэнлүүгээ унтраалаа.

-Чи наад захидлаа хэн нэгнийг гуйгаад бичгийн машин дээр цохиулчихаач.

-Яах юм бэ? Би элдэв гуйлтаас бүр залхчихаад байна. Хагас цагийн турш дал модны навчсан дээврийг бороо балбах нь сонстоно. Хотхон яг л аадар бороонд живж байгаа мэт санагдана.

-Аль эрт л ингэх хэрэгтэй байсан юм. Үргэлж л ямар нэгэн зуучлагчгүйгээр хөдлөх хэрэгтэй шүү дээ хэмээн эхнэр нь үглэв.

-Хэзээ ч оройтно гэж байхгүй гэсээр хурандаа дусаал хаана гоожиж буйг олохыг оролдов. -Магадгүй энэ байшингийн барьцаанд тавьсан хугацаа дуусахаас өмнө асуудал шийдэгдэж юу магад.

-Одоо хоёр жил үлдсэн гэж эхнэрийг хэлэхэд хурандаа дэнлүүг асааж дусаал гоожиж буй газар тахианыхаа идүүрийг тавьж унтлагын өрөө рүүгээ эргэж оров.

-Тэд өөрийн мөнгийг хурдан авахын тулд асуудлыг нэгдүгээр сараас өмнө шийдэж магадгүй юм гэж өөртөө хэлээд энэ үгэндээ их л итгэж,

-Тэр үед Агустиныг нас барснаас хойш яг нэг жил болно. Тэгээд бид кинонд явна гэж хэлээд инээмсэглэв.

-Кино ямар байдгийг би бүр мартжээ. Хурандаа түүн рүү хараад:

-Чи хамгийн сүүлд хэзээ кино үзлээ?

-1931 онд юм байна. “Үхдлийн сүүлчийн хүсэл” гэдэг кино байсан.

-Тэнд чинь тэгээд зодоон гарах юм уу?

-Би тэрийг нь сайн мэдээгүй. Хий үзэгдэл бүсгүйн сондорыг хулгайлахыг завдах хэсэг дээр бороо орчихсон юм...

Тэд борооны чимээнд нойрсчээ. Хурандаагийн ходоод нь өвдөжэхлэв. Гэвч энэ нь түүнийг айлгасангүй. Тэрбээр бас дахин нэг аравдугаар сарыг даван туулсан мэт санав. Ноосон хөнжлөөр биеэ ороож хэсэг хугацаанд хаа нэгэн холоос сонсох мэт эхнэрийнхээ хэржигнэсэн амьсгалыг чагнаж байснаа гүн нойронд авгжээ.

Түүнийг сэрүүн байгаа аятай ярьж эхлэхэд эхнэр нь сэрэв.

-Чи хэнтэй яриад байна аа?

-Хэнтэй ч биш. Макондод болсон тэр хурал дээр бидний зөв байсан тухай л бодсон юм. Бид хурандаа Аурелиано Буэндиад бууж өгч болохгүй гэдгийг хэлж байсан. Гэвч тэр бидний үгийг сонсоогүйгээс бүх юм талаар өнгөрсөн.

Долоо хоногийн туршид бороо шаагисаар байлаа. Арваннэгдүгээр сарын хоёронд хурандаа мянга эсэргүүцсэн боловч эхнэр нь Агустины шарил дээр цэцэг тавихаар явжээ. Түүнийг оршуулгын газраас эргэж ирэхэд аль хэдийнээ багтраа өвчин нь эхэлж маш хүндхэн долоо хоног үргэлжилжээ. Тэр ч бүү хэл хурандаагийн давж туулна гэдэгтээ үл итгэж байсан аравдугаар сарын дөрвөн долоо хоногоос ч ил үү хүндхэн өдрүүд тохиолоо. Эмч өвчтөнийг үзээд,

-Иймэрхүү багтрааг хүнд гэж ойлговол ч би энэ хотынхныг бүгдийг нь л оршуулахаас наагуур болно шүү гэв.

Гэвч дараа нь хурандаатай ганцаарчлан уулзаад хэвтрийн маш хатуу дэглэм барихыг зөвлөжээ.

Хурандаагийн бие ч гэсэн доройтжээ. Тэрбээр бие засах өрөөнд хар хөлсөө дуслуулан

хэдэн цагаар ч хамаагүй сууж ихэд тарчилж байхад түүний дотор эрхтэн

ялзарч, олон хэсэг болон тасарч байгаа мэт санагдана.

-Энэ бол зөвхөн өвөл шүү. Бороо зогсмогц бүх юм өөр болно гэж тэрбээр гутрахгүйн тулд өөрийгөө тайвшруулна. Тэрбээр өөрт нь захидал ирэх тэр өдрийг хүртэл заавал ч үгүй амьд явах учиртай гэдэгт үнэн сэтгэлээсээ итгэж байлаа. Одоо бол түүний хувьд ар гэрийн ажлыг гүйцэлдүүлэх ээлж болжээ. Шүдээ хавиран хөрш лангуунаас зээлээр хоол хүнс гуйх нь ч энүүхэнд.

-Ердөө л дараачийн долоо хоног хүртэл. Ирэх баасан гаригт би бага сага мөнгө авах ёстой хэмээн өөрийнхөө хэлсэнд ч итгэлгүй ярих үе гарна.

Эхнэрийн биеийн байдал дээрдмэгц тэрээр нөхрөө ямар болсныг хараад мэл гайхав.

-Зүгээр л нэг хэлхээтэй яс байна шүү дээ.

-Худалдаанд гарахад бэлдэж байна. Бишгүүр хөгжмийн үйлдвэрээс захиалга авсан гэж хурандаа тохуурхав.

Мөн чанартаа тэрбээр ганц захидалд найдвар тавьж байлаа. Нойргүйдлээс болж яс нь янгинаж, гэрийн аж ахуй, азарган тахианд тавих халамж нь түүнийг дээд зэргээр туйлдуулжээ. Арваннэгдүгээр сарын сүүл гэхэд тахиа нь хоёр хоног эрдэнэ шишгүй байснаас болж үхэж ч магадгүй байдалд хүрэв. Энэ үед тэрбээр аль өнгөрсөн долдугаар сард зуухан дээр өлгөсөн атга вандуйн тухай гэнэтхэн саналаа. Тэр хальсыг цэвэрлэж тахианы тавганд хуурай үрийг нь хийжээ.

-Наашаа хүрээд ир гэж эхнэр нь дуудав.

-Одоохон. Өлссөн ч гэсэн ийм юм иднэ ч гэж хэцүү дээ гэсээр тэр тахианыхаа байдлыг ажиглана.

Эхнэр нь орноос өндийхөд ор шажигнан дуугарав. Түүнээс элдэв дээдийн эм ханхлах ажээ.

-Чи наад тахианаасаа түргэн салах хэрэгтэй дээ гэж тэрээр үг бүрээ тодотгон хэлэв. Хурандаа хэзээ нэгэн цагт эдгээр үгсийг сонсоно гэдгээ мэдэж байлаа. Хүүгийнх нь амийг бүрэлгэсэн тэр өдрөөс хойш азарган тахиаг нь амьд мэнд авч үлдэхийг шийдсэн тэр цагаас л ийм үг сонсоно гэж хүлээж байжээ. Түүнд хариу бодох хугацаа байв.

-Одоо ч хэрэггүй биз дээ. Гурван сарын дараа тахианы зодоон болно. Тэр үед бид илүү өндөр үнэ хүргэнээ.

-Хэргийн учир мөнгөндөө биш ээ. Хүүхдүүдийг ирэхээр наадахаа өгөөд юу санаснаа хийцгээ гэж тэдэнд хэлсэн нь дээр.

-Энэ бүхэн чинь Агустины дурсгалыг хүндэтгэсэн зүйл шүү дээ. Тахианыхаа ялалтын

тухай тэр бидэнд яаж нүүр бардам ярих байсныг чи төсөөлөөд үз дээ гэж хурандаа бэлдсэн хариугаа барилаа.

Эзэгтэй хүүгийнхээ тухай бодов.

-Энэ гайтай тахианууд л түүнийг алсан. Хэрэв нэгдүгээр сарын гурванд тэр гэртээ байсан бол ийм аймшигтай юм болохгүй байсан гэж хэлээд хатангир хуруугаараа үүд рүү зааж:

-Хүүгийн минь тахиагаа сугавчилсаар гэрээс гарч явах нь одоо ч нүдэнд минь харагдсаар л байна. Тахиа зодолдуулаад хэрэггүй, чамд гай л авчирна гэж би түүнд олон удаа сануулж байсан. Гэтэл хүү минь инээд алдаад “Юу гэж тэгэхэв дээ, ээж ээ. Өнөө орой гэхэд бид мөнгөө хийх газраа олохоо байна” гээд л гарсандаг...

Сулдаж ядарсан тэрээр орондоо эргэж хэвтэв. Хурандаа түүний дэрийг болгоомжтойхон засав. Тэдний харц тулгарахад түүний нүд өөрийнхтэй нь бүх талаараа ихэд адилхан санагджээ. Түүний хэнхдэгт ямар нэгэн юм шуухитнахыг сонсмогц тэрбээр:

-Хөгшөөн, хөдлөхгүйг хичээгээрэй гэжээ.

Эмэгтэй бүхнийг умартан нүдээ анилаа. Харин дахин нүдээ нээмэгц түүний амьсгал арай тайван болсон байв.

-Энэ бүхэн бидний гуйлгачин байдлаас л болж байгаа хэрэг.Тахиа хооллохын тулд идэх талхаа багасгана гэдэг бол нүгэл гэж тэрээр өгүүлэв.

Хурандаа орны даавууны үзүүрээр түүний духыг арчаад,

-Гурван сардаа ч арай үхчихгүй байлгүй дээ гэвэл, -Тэгээд бид гурван сар юу идэх болж байна аа? хэмээн эхнэр асуув.

-Мэдэхгүй ээ. Хэрэв бид өлсгөлөнгөөс болж үхэх хувь заяатай байсан бол аль хэдийнээ чадхийчих байсан байлгүй.

Азарган тахиа юу ч болоогүй мэт хоосон тавагныхаа өмнө зогсохдоо хурандааг хараад ихэд гомдолтой хоолой нь зангиран дуугарав. Хурандаа түүнийг харж инээвхийлснээ:

-Анд минь, амьдрал гэдэг амаргүй эд юм даа гэв.

Хурандаа гэрээс гарч гудмаар юу ч бодолгүй алхах зуур ямар нэгэн гарц байгаа гэдэгт өөрийгөө итгүүлэхийг ч үл хүсэв. Тийн тэнхээ тасартал хүнгүй гудамжаар хэсүүчлээд эргэж ирвэл эхнэр нь түүнийг ирэхийг сонсоод өрөөндөө дуудав.

-Чамд юу хэрэгтэй юм бэ?

-Бид цагаа зарж болох юм байна гэж тэрээр хариулав. Хурандаа энэ тухай бодож байлаа.

-Апварог би шуудхан дөчин песо өгнө гэдэгт итгэлтэй байна. Түүнийг чи оёдлын машин худалдаж авсаныг санаж байна уу? гэв.

Тэрээр Агустины ажиллаж байсан гуталчны газрын эзнийг хэлжээ.

-Маргааш өглөө би түүнтэй уулзана аа хэмээн хурандаа зөвшөөрөв.

-Заавал өглөө болтол хойшлуулаад яадаг юм.

Одоохон аваачижтүүний ширээн дээр тавиад.”Альваро, би чамд зарах цаг авчирлаа” гээд л хэлчих. Тэр бүхнийг ойлгоно.

Хурандаа амьдралдаа гутрав.

-Энэ нь яг л дээдсийн авсыг дээрээ өргөж явахтай адилхан шүү дээ. Хэрэв гудамжинд намайг ийм юм барьчихсан явж байхыг харвал миний тухай Рафаэль Эскалоныг дууриаж дуу аялах болно.

Гэвч энэ удаа ч гэсэн эхнэр нь түүнд итгүүлж чадаад ханын цагийг авч сонинд ороож өгөхдөө,

-Дөчин песогүй бол битгий ирээрэй гэв. Хурандаа сугандаа боодолтой зүйл сугавчилсаар гуталчны газрыг зүглэв. Довжоон дээр Агустины андууд сууж байлаа. Тэдний нэг нь дэргэдээ суухыг урив. Хурандаад их л тавгүй санагдаад ирэв.

-Зүгээрээ. Битанайхажуугаарявжбайсан юм гэхүед засварын өрөөнөөс Апваро гарч ирээд хонгилд татсан хэцэн дээр нойтон даавуу тохов. Альваро бол нүд нь гялалзсан, биерхүү залуу байлаа. Тэр бас л хурандааг суухыг урихад аргагүйн эрхэнд Апварог ганцаараа үлдэхийг хүлээхээр шийдэн хаалганы дэргэдэх модон сандал дээр суулаа. Төдөлгүй тэр эргэн тойрны хүмүүс бүгд л хүн чулуу мэт суусаар байхыг анзаарчээ.

-Би саад болоогүй биз? гэвэл залуус унтууцаж, нэг нь хурандаа руу дөхөж сууснаа:

-Энд Агустины бичсэн зарим нэг зүйл байгаа гэв. Хурандаа ийш тийш харсан боловч гудамж хоосон байлаа.

-Ухуулах хуудсанд тэгээд юу гэсэн байх юм?

-Үргэлж байдаг л юм байна. Түүнд ухуулах хуудсыг өгөв. Хурандаа түүнийг авч өмднийхөө халаасанд нуулаа. Түүнийг бүгд л сониучирхан харж буй гэдгийг тэрбээр мэдэх хүртэл боодолтой зүйлээ хуруугаараа тогшин дуугүйхэн суусаар байв. Хурандаа сандарсандаа яах ч учраа олсонгүй.

-Та юу авчирсан юм бэ?

Хурандаа Херманы няхуур ширтэх ногоон нүдтэй тулгарахгүйг хичээгээд,

-Юу ч биш ээ. Герман эрд цагаа засуулахаар л авч явна гэж залав.

-Хурандаа та зөрүүдлэх хэрэггүй. Түүнийг чинь би үзээд өгье гэсээр Херман түүнээс боодолтой юмыг авахаар завдав. Гэвч хурандаа цагийг өгсөнгүй. Тэрбээр үснийхээ угийг хүртэл улаасан боловч ганц ч үг ганхийсэнгүй. Гэвч залуус түүнийг шалсаар байлаа.

-Хурандаа, та түүнд цагаа өгчих л дөө. Тэр засчих байх гэцгээнэ.

-Би хэнд ч хүндрэл учруулахыг хүсэхгүй байна.

-Хүндрэл учруулах юм юу байхав дээ. Герман эр танаас арван песо тоншчихоод юуг нь ч засч өгөхгүй

шүү дээ гэж Херман ундууцав. Эцэс сүүлд нь тэр цагийг авлаа.

Херман цагийг барьсаар засварын өрөөнд оров. Альваро оёдлын машинаар юм оёж сууна. Өрөөний мухарт нэгэн бүсгүй суух агаад тэрээр товч хадаж байлаа. Түүний дээхэн талд өлгөөтэй гитар харагдана. Харин гитар дээр “Улс төр ярихыг хориглоно” гэсэн бичээс зурайх ажээ. Хурандаа гараа хаашаа хийхийг мэдэлгүй хөлөө сандлын хөндлөвч дээр тавьтал,

-Ёстой л нэг новшийн амьдрал юм даа гэх дуулдав.

Хурандаа унтууцаж,

- Хараал хэлэхийн хэрэг юу байна? гэвэл Альфонсо шилээ зүүгээд хурандаагийн гутлыг анхааралтай ажиглаж байснаа,

-Та ч ёстой л нэг өөртөө гялгардсан гутал углачихсан байх шив дээ гэв.

-Гэхдээ үүнийг чинь илүү дутуу бүдүүлэг үг хэрэглэлгүйгээр хэлчихэж болно шүү дээ гээд чийдсэн гутлынхаа улыг үзүүлэв. -Дөч хүрсэн эр, дөрөө дарсан ат гэгчээр энэ аймшгийн амьтад амьдралдаа анх удаа иймэрхүү хараалын үгс урсгаагүй нь лавгай үнэн буй

-Бэлэн боллоо гэж Херманыг орилсоор гарч ирэхэд цаг нь ч дуугарав.

Хөрш байшингийн ханыг нэгэн эмэгтэй балбаж:

-Агустин нас бараад нэг ч жил болоогүй байхад наад гитараа хангинуулахаа болиоч ээ гэж орилох нь сонстов. Бүгд инээлдэв.

-Энэ чинь цаг шүү дээ. Херман гартаа ханын цаг барьсаар гарч ирлээ.

-Санаа зоволтгүй ээ. Хэрэв хүсвэл би цуг явж цагийг тань өлгөхөд тусалъя гэв. Хурандаа татгалзав.

-Би хэдийг төлөх вэ?

-Хурандаа, та санаа зоволтгүй. Нэгдүгээр сард бүгдийг нь азарган тахиа төлчихнө гээд Херман сандал дээр суув. Хурандаа цаг нь болсон гэж бодлоо.

-Би чамд нэг юм хэлэх гэж ирсэн юм.

-Ямар юм?

-Чамд би тахиагаа бэлэглэе. Та нарт би түүнийг бэлэглэж байна гэж хэлээд тэр бүгдийг тойруулж харав. Херман түүнийг бодлогошронгүйгээр ажиглаж байв.

-Би хэтэрхий хөгширчээ. Надад ахадсан хариуцлага байна. Хэд хоногийн дараа түүнийг үхчихэж магадгүй гэж санагдах юм гэхдээ хурандаагийн хоолой үнэхээр зангирч байлаа.

-Хурандаа та сэтгэлээ дэмий зовоох юм. Өдийд азарган тахианууд өдөө гээдэг. Тэдний арьс нь өрөвсчихсэн байдаг юм гэж Апьфонсо хэлэв.

-Сарын дараа тэр зүгээр болно хэмээн Херман ч нэмж ятгажээ.

-Ямар ч байсан цаашид би түүнийг тэжээхийг хүсэхгүй байна гэж хурандаа халаглав. Херманы нүд аягандаа эргэлдэж:

-Ойлго л доо, хурандаа. Агустины азарган тахиаг та л тэр тулаан болох газар авчрах нь маш чухал хэмээн ятгасаар байлаа. Хурандаа дуугаа хураав.

-Би ойлгож байна. Тиймээс өнөөг хүртэл түүнийг тэжээсээр ирлээ. Хамгийн муухай нь ахиад гурван сар үлдсэнд л хамаг учир байгаа юм гэж тэрбээр шүдээ хавиран хэлэв. Херман бүгдийг ойлгожээ.

-Хэрэв асуудал үүнд л байгаа юм бол үүнээс хялбар юм гэж байхгүй гээд өөрийн саналаа хэлвэл бусад нь дэмжив. Хурандааг боодолтой цагаа сугавчилсаар үдэш гэртээ ирэхэд эхнэр нь түүнийг угтаад:

-Юу ч болсонгүй юу? гэж асуужээ.

-Юу ч үгүй. Гэхдээ энэ чухал биш. Хүүхдүүд тахиаг хооллохоор болсон гэв...

-Хүлээзнээрэй, би танд шүхэр өгье.

Ноён Сабас ханын шүүгээг нээв. Тэнд эмх замбараагүй байх агаад хаана юу байгаа нь огт мэдэгдэхээргүй байлаа. Шүүгээний дээд хэсэгт эрэгтэй хүний баахан шүхэр, мөн эмэгтэй хүний нарны хаалт зэрэг үзэгдэв. Энэ бүхнийг харахад эрт дээр үед болсон ослын дараах хаягдлыг санагдуулна.

-Танд их баярлалаа. Гэхдээ би бороо намдахыг хүлээзнэе гэж тэр хэлэв. Ноён Сабас ханын шүүгээг хаасангүй. Тэрбээр цахилгаан сэнсээр үлээлгэхийн тулд бичгийн ширээний ард суулаа. Дараа нь хөвөнд боолттой тариур бүхий хайрцгийг гаргав. Бороонд норох буйлсан

модод тугалган өнгөтэй мэт санагдана. Гудамжинд нэг ч хүн байсангүй.

-Бороо орж байгааг цонхоор харахад шал өөр харагдах юм. Яг л өөр нэгэн хотод орж байгаа юм шиг...

-Хаанаас нь ч харсан бороо бол бороо гэж ноён Сабас хариулжээ. Тэрбээр тариурыг буцалгав.

-Энэ ёстой новшийн хот юм.

Хурандаа мөрөө хавчив. Түүний өрөөнд тод өнгийн бөс даавуугаар бүрсэн тавилга байх агаад буланд нь шуудайтай давс, торхтой зөгийн бал, морины эмээл сэлтийг овоолж хаясан байх аж. Ноён Сабас хурандаа руу үл тоосон мэт харна.

-Таны оронд бол би ингэж бодохгүй байсан гэж хурандаа хэлэв. Тэрбээр хөлөө ачин суугаад, бичгийн ширээний ард тонгойн суух ноён Сабас руу тайван ширтэв. Түүний өмнө байдгаараа хөөж шалхайсан, нүдэндээ мэлхийн гунигтай жижигхэн хүн байлаа.

-Харин та өөрийгөө эмчид үзүүлсэн нь дээр байх. Та нарын хэн нь ч оршуулга болсон өдрөөс хойш ер сэхэл авахгүй юм хэмээн ноён Сабас хэлэв. Хурандаа толгой өндийлгөөд,

-Миний бие тэнхээ маш сайн байна гэж үг зөрөв. Ноён Сабас тариур буцлахыг хүлээнгээ

-Би өөрийнхөө тухай янз бүрийн юм хэлж чадна. Гэхдээ та бол гутлын зэс даравчийг ч тоолгүй идэж дөнгөх айхтар хүн шүү гэж хурандааг даапаалснаа саарал толботой үсэрхэг гараа ажив. Хуримын бөгжнөөс гадна тэрбээр хуруундаа хар чулуун шигтгээтэй бэлзэг зүүсэн байв.

-Би чадна гэж хурандаа батлан хэлэв. Ноён Сабас албан өрөөг байшингийн бусад хэсэгтэй холбодог хаалгаар толгойгоо цухуйлган эхнэрээ дуудлаа.

Дараа нь өөрийн барьж буй хоолны дэглэмийн тухай сэтгэл зүсэм тайлбарууд урсгаж гарав. Чингэснээ цамцныхаа халааснаас нэгэн гожгор шил гаргаж сэгсрээд вандуй шиг цагаан эмийг ширээн дээр гаргаж тавилаа.

-Үүнийг байнга биедээ авч явна гэдэгямар ихзовлон гэж бодно? Яг л өөрийн үхлээ авч яваа мэт санагддаг юм гэж хэлэв.

Хурандаа ширээ рүү дөхөжочоод ноён Сабас эм гэж сануулах хүртэл алган дээрээ тавьж анхааралтайгаар ажиглав.

-Үүнийг кофе амтлахын тулд хэрэглэдэг юм. Ёотон нь ч ёотон. Гэхдээ чихэргүй гэж хурандаад тайлбарлахад

-Өө тийм үү. Энэ чинь хонхгүй хонхны дуутай яг адилхан юмаа гэж хурандаа хэлэв. Тэр маш исгэлэн хийгээд гашуун амтыг мэдэрч байлаа.

Ноён Сабасыг эхнэр нь тарих үед тэрбээр алгаараа нүүрээ таглаж, ширээ тохойлдон зогсов. Хурандаа яах ч учраа олохгүй байлаа. Эзэгтэй цахилгаан сэнсийг унтрааж мөнгөний төмөр авдран дээр аваачиж тавиад ханын шүүгээ рүү дөхөж очив.

-Энэ шүхрүүдийг харахлаар яагаад ч юм, үхлийн тухай л санагдуулаад байдаг юм гэж хэлэхэд хурандаа түүний үгийг нэг их хайхарсангүй. Түүнийг тэднийхээс шуудан тосохоор дөрвөн цагийн алдад гарсан боловч аадар бороо ноён Сабасын дээвэр дор хэсэгтээ л хорогдоход хүргэсэн ба усан онгоц ирэхэд ч бороо орсоор л байлаа.

-Үхэл ирэхдээ эмэгтэй хүний дүрээр морилдог гэж ярьцгаадаг юм билээ хэмээн ноён Сабасын эхнэр үргэлжлүүлэн ярив. Тэрээр нөхрөөсөө өндөр, тарган хийгээд дээд уруул дээрээ томоо үүтэй нэгэн ажээ. Түүний ярих нь яг л сэнсийг санагдуулна.

-Миний бодлоор бол тэр заавал эмэгтэй хүн байх ёсгүй гэж би бодож байна. Тэр бол ямар нэгэн туурайтай амьтантай адилхан байх ёстой гэж би боддог юм гэж тэрээр нэмж хэлэв.

-Магадгүй юм. Энэ хорвоо дээр юу эс тохиолдох билээ дээ гэж хурандаа санал нийлэв. Тэр хулдаасан цув нөмөрсөн шуудан зөөгчийн тухай бодолд автлаа. Хурандаа өмгөөлөгчөө сольсноос хойш нэг сар өнгөрчээ. Хариу ирэх цаг ч болсон аж. Ноён Сабасын эхнэр хурандаа яриаг нь ер сонсохгүй байгааг анзаартлаа үхлийн тухай үргэлжлүүлэн бурсаар байлаа.

-Эрхэм ээ! Та ямар нэгэн юманд санаа зовоо юу? гэж тэрээр асуув.

-Тийм ээ. Таны зөв. Оройн таван цаг болчихоод байхад би тахиандаа тариа хийхээ мартсан гэдгийг сая л саналаа гэж худал залсанд гэрийн эзэгтэй ихэд гайхцран,

-Азарган тахиаг яг л хүн шиг тарина гэв үү? Ямар аймаар юм бэ? гээд уулга алдав. Ноён Сабас тэссэнгүй уравгар царайгаа үрчийлгээд,

-Чи жаахан ч болов амаа хамхиач. Бараг хагас цаг л эрхмийг өөрийн тэнэг яриагаар залхаалаа гэхэд л сая амаа гараараа дарав.

- Юу гэсэн үг вэ? Тийм юм байхгүй гэж хурандааг эсэргүүцтэл гомдсон гэрийн эзэгтэй хаалга саван гарлаа. Ноён Сабас өмднийхөө халааснаас алчуур гаргаж хүзүүгээ арчив. Хурандааг цонх руу очиход бороо орсоор л байлаа. Хэн нэгний тахиа хоосон талбайг гатлан ус үсчүүлэн явж харагдана.

- Та үнэхээр тахианд тариа хийдэг юм уу?

- Тийм ээ. Дараагийн долоо хоногт бэлтгэл сургуулилт эхлэнэ гэж хурандаа хэлэв.

- Энэ бол утгагүй зүйл. Таны хийх ажил ч биш дээ гэж ноён Сабас айлдав.

- Санал нэг байна. Гэхдээ энэ чинь тахианы хүзүүг мушгих шалтгаан биш шүү дээ гэж хурандаа зөрүүдлэв.

- Та яасан зөрүүд хүн бэ? гэсээр ноён Сабас цонх руу дөхөн очиход түүний хэржигнэсэн амьсгаа нь муурын цээжийг санагдуулна. Хурандаа түүнийг өрөвдөв.

- Эрхэм ээ, та миний зөвлөгөөг сонсооч. Та тэр тахиагаа оройтоогүй дээрээ зарсан нь дээр дээ гэж ноён Сабас ятгалаа.

- Оройтно гэж хэзээ ч үгүй.

- Та ухаантай байгаач. Та нэг сумаар хоёр туулай онох болно шүү дээ. Нэг талаасаа та толгойны өвчнөөсөө сална. Нөгөөтэйгүүр халаасандаа есөн зуун песотой болно гэж ноён Сабас дахиад л ятгав.

- Есөн зуун песо? гээд хурандаа санаа алдав.

- Тийм ээ, есөн зуу.

Хурандаа тэр их мөнгийг төсөөлөх гэж оролдлоо.

Тахианы үнэд ийм их мөнгө төлнө гэж үү?

- Төлөхөөр барах уу. Би үүнд итгэлтэй байна гэж ноён Сабас хэллээ.

Хурандаа ийм их хэмжээний мөнгийг хувьсгалт армийн сангийн хөрөнгийг хүлээлгэж өгсөн тэр цагаас хойш гартаа ер барьж үзээгүй билээ.

Түүнийг ноён Сабасын албан өрөөнөөс гармагц нарийн гэдэс нь зангирсан мэт өвдөж байлаа. Гэвч цаг агаар үүнд огтхон ч буруугүй юм. Тэр шуудан дээр очоод шууд л шуудан зөөгчийг чиглээд:

- Би яаралтай захиа хүлээж байна. Онгоцоор ирэх захиа байгаа юм гэв.

Шуудан зөөгч хайрцган дахь дугтуйнуудыг ялгаснаа юу ч хэлэлгүй тэднийг буцааж хийгээд хоёр алгаа дээш нь харуулан хурандаа руу гайхсан байдалтай ширтэв.

- Гэхдээ өнөөдөр захиа ирэх ёстой байсан гэхэд шуудан зөөгч мөрөө хавчсанаа:

- Хурандаа минь, ганцхан үхэл л заавал ч үгүй ирдэг юм шүү дээ гэв.

Хурандаагийн эхнэр эрдэнэ шишийн зутан бэлтгээд түүнийг хүлээж байлаа. Түүнийг гүн бодолд авган зутангаа ар араас нь зайтайхан, дуугүйхэн халбагдахад харж суусан эхнэр нь ямар нэгэн өөрчлөлтийг анзаарч: -Юу болоо вэ? гэж асуулаа.

- Миний тэтгэврийн хувь заяа шалтгаалах түшмэлийн тухай би бодож сууна. Биднийг тавин жилийн дараа хөрст дэлхийдээ тайван нойрсож байхад тэр нэг хөөрхий амьтан баасан гариг бүр өөрийн тэтгэврийг хүлээсээр байх болно гэж хурандаа худал ярив.

-Муугийн л ёр байна. Энэ чинь чамайг бууж өгч байгааг харуулж байгаа юм биш үү

гэж эхнэр нь хэлэв. Тэрээр зугангаа халбагадаж эхэллээ. Хэсэг хормын дараа тэр нөхөртөө хандан:

-Чи наад зугангаа идвэл дээр юмсан.

-Маш сайхан зуган байна. Чи хаанаас эрдэнэ шиш олоов? гэж хурандаа асуув.

-Азарган тахианаасаа л авлаа. Хүүхдүүд түүнд барахааргүй ихийг авчирч өгсөн болохоор тэр маань бидэнтэй хуваалцахыг хүснэ биз дээ? Амьдрал тийм л юм чинь.

-Тийм нь ч тийм шүү. Амьдрал бол эх дэлхий дээрх хамгийн сайн бүтээл туурвил юм гээд хурандаа санаа алдав. Тэрбээр зуухны хөлнөөс хүлсэн тахиагаа харахад урьдынхаасаа өөр харагдах шиг санагджээ. Эхнэр ч мөн тахиа руу өнгийв.

-Өнөөдөр би хүүхдүүдийг мод барьж хөөсөн. Тэд түүний янзыг үзэхээр хөгшин эм тахиа авчирсан юм.

-Энэ чинь тэгээд юу нь сонин байгаа юм. Биднийг ямар нэг тосгон эзлэх үед хурандаа Аурелиано Буэндиад иймэрхүү зүйл зөндөө л тохиолдож байсан. Тэгэхэд түүнд ч бас хүүхэн авчирч өгдөг байсан шүү дээ гэсэн хурандаагийн үг эхнэрт нь ихэд таалагджээ.

Азарган тахиа хүний хоолойтой тун ижилхэн хоолойгоор дуугарав.

-Заримдаа би энэ шувууг хэзээ мөдгүй ярих байх гэж боддог шүү гэж эхнэрийгээ хэлэхэд хурандаа дахиад л тахиа руу харлаа.

-Зоосон мөнгөний дуу шиг цээлхэн хоолойтой тахиа байгаа юм даа, энэ чинь. Биднийг лав гурван жил өлхөн тэжээнэ шүү гэсээр зугангаа зажилж суулаа.

-Мөрөөдөхөд ямар мөнгө төлөх биш дээ.

-Мөрөөдөл тэжээхгүй ч гэсэн ноён Сабасын шидэт эм шиг ач тусаа өгнөө гэж хурандаа хариу өчив. Тэрбээр дотроо нэгийг бодон нойр муутай хоножээ. Маргааш нь түүний эхнэр эрдэнэ шишийн зугангаа түүнд дахин аягалж өгчихөөд өөрөө доош харан ганц ч үг ганхийлгүй халбагадаж гарав.

-Чи яагаа вэ?

-Зүгээр ээ. Одоо түүний худал ярих ээлж эхлэв. Хурандаа түүнийг тайтгаруулахыг оролдоно. Гэвч тэрээр түүний үгийг ер тоосон шинжгүй байлаа.

-Үнэхээр юу ч болоогүй дээ. Би зүгээр л оршуулга болсноос хойш хоёр сар өнгөрчихөөд байхад эмгэнэл илэрхийлж чадаагүй тухайгаа л бодож байна ...

Энэ орой тэр талийгаачийнд очихоор шийджээ. Хурандаа түүнийг дөхүүлж өгөөд өөрөө кинотеатрыг зүглэв. Анхель ламтан байшингийнхаа үүдэн дээр суучихсан хонхны дуу арван хоёр удаа дуугарч анхааруулсан дохио өгсөөр атал тэнд цугларагсдын хэн нь кино

үзэхээр орж буйг ажиглана. Гэрлийн урсгал, чанга хөгжим хийгээд хүүхдүүдийн шуугилдаан Анхель ламтны хоригт хүчтэй эсэргүүцэл болох ажгуу. Нэгэн хөвгүүн хурандаа руу модон буу шагайж,

-Тахиа яаж байна, хурандаа? гэж тэр сүрхий чанга дуугаар асуулаа.

Хурандаа гараа саваад,

-Бүх юм хэвийн гэв.

Барилгын нүүрэн талыг том цагаан даавуун дээр солонгын долоон өнгийг хослуулан будаж чимэглэсэн “Шөнө дундын охин” хэмээх киноны зарлал халхалж байлаа. Дээр нь гуя хасаа гялалзуулсан цагаан даашинзтай эмэгтэйг дүрсэлжээ. Тэртээд цахилгаан цахилж, аянга ниргэх нь сонстох хүртэл кино театрын орчмоор дэмий сэлгүүцсэнээ хурандаа эхнэрийнхээ араас явлаа. Гэвч тэр талийгаачийнд ч, гэртээ ч байсангүй. Ханын цаг зогссон байвч комендантын цаг хүртэл бага хугацаа үлдсэн гэдгийг гадарлаж байлаа. Тэрбээр аадар бороо айсуйг сонсож зогсов. Түүнийг эхнэрээ хайхаар гарах гэтэл тэр орж ирлээ. Хурандаа тахиагаа унтлагын өрөө рүү оруулаад хувцсаа сольж зочны өрөө рүү ус уухаар явангаа “Чи хаана байсан юм бэ?” гэж асуулаа.

-Тэнд л байсан. Өнөөдөр ийм эрт бороо орно гэжхэн ч бодсонгүй гэсээр савтай уснаас шилэн аяганд хийгээд унтлагын өрөө рүү оров. Хурандаа дуугаа хурааж бүрэн дуу сонстоход цагийн зүүг арван нэг дээр тааруулан тавьж шилэн нүүрийг нь хаагаад сандлыг байранд нь аваачиж тавилаа. Эхнэр нь эрхиэ эргүүлэн залбирч байлаа.

-Чи миний асуултанд хариулсангүй гэж хурандаа уурлав.

-Ямар?

-Чи хаана байсан юм бэ?

-Тэднийд л суусаар удчихлаа. Би өчнөөн удаан гэрээсээ гараагүй шүү дээ гэж тэр хариулав.

Хурандаа дүүжин ороо өлгөөд хаалгаа түгжин, хортон шавьжнаас хамгаалах шингэнээ цацав. Дараа нь дэнлүүг шалан дээр тавьж дүүжин орондоо эвтэйхэн хэвтлээ.

-Би чамайг ойлгож байна. Хамгийн муухай нь бидэн шиг хэцүү амьдарч байгаа хүмүүс худал хэлэх нь л ичгүүртэй юм гэж тэр гунигтайхан өгүүлээд санаа алдлаа.

-Би Анхель ламтанд бараалхсан юм. Хуримынхаа бөгжийг тавиад түүнээс мөнгө зээлэх гэлээ.

-Тэр тэгээд юу гэж байна?

-Гэгээн зүйлийг худалдана гэдэг нүгэл гэсэн.

-Хоёр хоногийн өмнө би цагаа зарахыг оролдсон. Гэвч нүүр нь гэрэлтдэг орчин үеийн шинэ цагнууд хаа сайгүй зарагдаж байхад одоо тэр хэнд ч хэрэггүй болжээ. Дөчин жилийн хамтын амьдралын туршид өлсгөлөн хийгээд зовлонг хамтдаа туулах хугацаанд түүний эхнэр ямар хүн болохыг одоо болтол бүрэн дүүрэн таниагүй юм байна даа гэж хурандаа дотроо бодов. Тэдний хайр сэтгэл ч мөн нэгэн адил хөгширчээ.

-Тэгээд тэр ханын зураг ч гэсэн хэнд ч хэрэггүй юм уу? Бараг бүх л айлд ийм зураг өлгөөтэй байдаг шүү дээ. Тэр ч бүү хэл би түрэгүүдийн лангуун дээр байхыг нь хүртэл харсан гэж тэрбээр хэлэв.

-За, одоо ч биднийг өлсгөлөнгөөр үхэж байгаа гэдгийг хүн болгон мэдлээ дээ.

-Би маш их ядарч байна. Эрчүүд ямар гэр орны ажил гэж мэдэх биш. Хөршүүддээ муугаа үзүүлэхгүйн тулд би олон ч удаа хоолны саванд чулуу хийж гал дээр тавьж байлаа гэж эзэгтэй гоморхлын үгс чудуудахад хурандаа ичих шиг болов.

-Бид үнэхээр доошоо оржээ.

Эхнэр нь шумуулнаас хамгаалах торон доороос өндийж ирээд дүүжин орны дэргэд очив.

-Үнэндээ би манай гэрт тогтсон урин зөөлөн уур амьсгалыг эцэс болгохыг хүсч байна. Би ханатлаа хүлцэнгүй байж нэр хүндээ гэсээр өдийг хүрлээ.

Түүний хоолой бухимдсанаас болж цааш оржээ. Гэвч хурандаагийн царай ер хувирсангүй.

-Сонгууль бүрийн дараа чамд сайн сайхан зүйл амладаг байсан. Гэтэл өнгөрсөн хорин жилийн дотор бид юу хүртсэн юм бэ? Хүүгийнхээ үхлээс өөр юу ч хүртээгүй!

Иймэрхүү ярианд хурандаа бүр дөжирч залхсан тул,

-Бид өөрт ноогдсон үүргийг л гүйцэтгэж байна гэж хариулав.

-Гэтэл сенатад байгаа хүмүүс чинь хорин жилийн турш сар бүр мянган песо авч өөрийн ажлыг явуулж байна шүү дээ гэсээр эзэгтэй асч гарав. -Ядаж ноён Сабасыг аваад үз л дээ. Ямар сайндаа л хоёр давхар байшинтай, мөнгөө хийх газаргүй хүн явж байхав. Гэтэл тэрхотод ирэхдээ нэг муутэнүүлч наймаачин, хүзүүндээ амьд могой ороож эм тан зардаг гуйлгачин л байсан биз дээ.

-Гэвч тэр чинь чихрийн шижин өвчнөөс болж үхэх гэж байгаа хүн шүү гэж хурандааг өмөөрвөл,

-Харин чи бол өлсгөлөнгөөр үхэх гэж байгаа амьтан. Нэрээ идээд цадахгүй гэдгийг хэзээ чи ухаарах юм бэ гэж эхнэр нь хашгичив.

Энэ агшинд цахилгаан гялсхийв. Гудамжинд аянга цахилах нь сонстоход унтлагын

өрөөнд ч бас аянга ниргэх шиг нижигнэж, эцэс сүүлд нь орон доогуур орж замхрах шиг санагдана. Гэрийн эзэгтэй эрхиэ авахаар огло харайн босоход хурандаа өөрийн эрхгүй инээд алдав.

-Энэ бол ам хамхилгүй ярьсны чинь төлөөх анхааруулга шүү. Бурхан багш бид хоёр нэг намын хүмүүс гэж чамд би үргэлж хэлдэг байсан биз дээ? гэв.

Гэвч үнэн хэрэгтээ түүнд маш гунигтай байлаа. Төдөлгүй дэнлүүг унтрааж харанхуйн гүнд бодолд автан хэвтгээд Макондог эргэн дурслаа. Неерландын хэлэлцээрийн дагуух амлалт хэзээ биелэгдэхийг тэрбээр арван жил хүлээсэн юм. Хэт их халуунд амьсгал нь давчидсан эрэгтэй, эмэгтэй хүмүүс, гэрийн тэжээвэр амьтад, мөн элдэв эд хогшлыг дээвэрт нь тултал ачсан, шар өнгийн тоосонд дарагдсан галт тэргийг олж харсан билээ. Энэ бол гадил жимснээс саа өвчний үе байсан агаад нэгэн шөнийн дотор хотхон эрс өөрчлөгдөж авай.

-Гадилын үнэр авахаар миний гэдэс мушгиад баларч байна. Ерөөс би одоо явлаа гэж тэр үед хурандаа хэлж байв. Чингээд тэрбээр мянга есөн зуун зургаан оны зургадугаар сарын хорин долооны лхагва гаригийн өдрийн хоёр цаг арван найман хоромд Макондогоос бүрмөсөн явсан ажээ. Неерландыг дайснауд эзлэсэн тэр цагаас хойш, тоост хорвоо дээр хагас зуун жил амьдарч байж гэмээнэ ганц ч болов тайван хором түүнд ер байгаагүй гэдгийг тэр сая л нэг ухаараад нүдээ нээж,

-Энэ тухай одоо бодоод хэрэг байна уу даа гэж хурандаа хэлэв.

-Юун тухай вэ?

-Тахианы тухай. Маргааш өглөө би түүнийг ноён Сабаст 900 песогоор зарчихна гэжхурандаа яриw. Албан өрөөний цонхноос ноён Сабасын хашгирах хийгээд засуулж буй мэт амьтдын орилох чимээ сонстоно.

-Хэрэв тэр арван хормын дараа гэхэд ирэхгүй бол би явах нь зүйтэй гэж хоёр цаг хүлээсний эцэст хурандаа шийдэв. Гэвч тэр дахин хорин хором хүлээв. Явахаар завдтал ноён Сабас болон түүний хамт хэдэн ажилчид албан өрөөнд орж ирлээ. Ноён Сабас хурандаагийн дэргэдүүр нэг бус удаа өнгөрсөн боловч түүн рүү өнгийж ч харсангүй. Гагцхүү ажилчдыг явсан хойно тэрбээр хурандааг анзаарав.

-Эрхэм ээ, та намайг хүлээж байна уу?

-Тийм ээ, эрхэм ээ. Хэрэв та одоо завгүй бол би хожуухан ирж болох юм. Ноён Сабас түүний яриаг сонсож дуусалгүй өрөөнөөс гарах зуур:

-Би одоохон ирнэ гэв.

Үд дундын нар өршөөлгүй шарж байлаа. Гудамжнаас тусах тод гэрэл албан өрөөнд тусна. Халуунаас залхсан хурандаа өөрийн эрхгүй нүдээ анихад түүний өмнө эхнэрийнх нь дүр тодров. Өрөөнд ноён Сабасын эхнэр орж ирлээ.

-Эрхэм ээ, та амар амар. Би зүгээр л хөшиг буулгах гэсэн юм. Тэгэхгүй бол энд яг л тамд байгаа юм шиг бүгчим байна гээд хөшгөө буулгаснаа:

-Та үргэлж зүүд үздэг үү? гэж асуулаа.

-Хааяа нэг. Би өөрийгөө дандаа аалзны торонд бариулж байна гэж зүүдэлдэг юм.

-Харин би шөнө бүхэн л хар даржзүүдэлдэг. Зүүдэнд үзэгдэх тэр хүмүүсийгхэн болохыг мэдмээр байх юм гэж Сабасын эхнэр хэлээд цахилгаан сэнсийг залгалаа.

-Өнгөрсөн долоо хоногт миний орны толгой дээр нэгэн эмэгтэй зогсож байхыг би харсан. Би зоригоо чангалж байгаад түүнээс хэн болохыг асуухад “Би энэ өрөөнд арван хоёр жилийн өмнө нас барсан хүн байна” гэж тэр хариулж байсан.

-Энэ байшин чинь баригдаад хоёр жил ч болоогүй шүү дээ гэж хурандааг хэлэхэд,

-Тийм ээ. Үхдлүүд ч бас алддаг болж таарах нь ээ гэв.

Хурандаагийн дотор эвгүйрхэв. Тэрбээр халуунд нозоорохоос гадна эзэгтэйн дэмий ярианаас үнэхээр залхжээ. Хурандаа хэсэг азнаснаа явахаар зэхгэл албан өрөөнд ноён Сабас захирагчийн хамт орж ирэв.

-Би чамд шөлийг чинь дөрвөн удаа халаалаа гэж эзэгтэй хэлвэл,

-Хэрэв чамд таалагдаж байгаа бол арван удаа ч халаасан яадаг юм. Одоо намайг тайван байлга гэж ноён Сабас бухимдав. Тэрбээр мөнгөний төмөр авдрыг онгойлгож захирагчид боодолтой мөнгө гаргаж өгөхөд захирагч хөшгийг нээж мөнгийг тоолов.

Ноён Сабас өрөөний мухарт сууж буй хурандааг харсан хэдий ч түүнийг ер хайхарсангүй. Тэрбээр захирагчтай үргэлжлүүлэн ярьсаар байлаа. Хурандаа тэднийг явахаар зэхэж буйг хараад суудлаасаа өндийвөл ноён Сабас үүдэн дээр зогссоноо:

-Эрхэм ээ, бид хоёрт ямар яриа байгаа билээ гэв. Захирагч хурандаа руу харж байгаа мэт санагдана.

-Онцын зүйл үгүй ээ, эрхэм ээ. Зүгээр л тантай ярилцах гэсэн юм.

-Тэгээд одоо яриач дээ. Надад ер зав алга гэж ноён Сабас хэлэв.

Тэрбээр хаалганы бариулаас барьж маш их яарсан байдалтай зогсоно. Хурандаа өөрийн амьдралд тохиолдсон хамгийн урт таван мөчийг тэгэхэд өнгөрүүлжээ. Тэрбээр шүдээ хавираад,

-Би нөгөө тахианы тухай л гэж аяархан шивнэлээ. Энэ үед ноён Сабас хаалгаа нээгээд.

-Тахианы тухай гэнэ шүү гэж давган хэлээд захирагч руу дохиж инээмсэглэн,

-Орчлон хорвоо сөнөж магадгүй байхад эрхэм нөхөр маань тахианы тухай л бодож байдаг. За яахав, эрхэм ээ, би одоохон эргээд ирнэ гэж хурандаад хандаж хэлэв.

Эрчүүдийн хөлийн чимээ хонгилд сонсогдохоо больтол хурандаа өрөөний голд огт хөдөлгөөнгүй зогссоны эцэст гадагш гарч хотхоноор жаал сэлгүүцэв.

Гутал засварын газар хэн ч байсангүй. Эмнэлэг хаалттай. Сиричүүдийн лангуун дээр тавьсан барааг хэн ч үл хянаана. Усан боомт дээр эгнүүлэн тавьсан шатахууны дөрвөн торхон дээр бүрх малгайгаар нүүрээ халхалсан нэгэн эр нойрсож байлаа. Хурандаа өөрийгөө энэ хотод үлдсэн цорын ганц амьд хүн шиг санасаар гэрийн зүг алхав.

Эхнэр нь үдийн хоолоо хийчихсэн хүлээж байлаа.

-Энэ бүхнийг би маргааш өглөө мөнгийг нь авчирч өгнө гэж амлаад авчихпаа гэж тэрээр тайлбарлав. Хооллох зуур хурандаа түүнд сүүлийн гурван цагийн дотор өөрт тохиолдсон золгүй явдлуудын тухай ярьж өгвөл эхнэр нь түүний яриаг арайхийн сонсож дуусгаад,

-Хамгийн гол нь чиний хүлцэнгүй зангаас л бүх юм болж байна. Чи гуйлгачин шиг биш харин юм үзсэн хүн шиг харц дээгүүр очиж уулзаад: “Эрхэм ээ, танд би азарган тахиагаа зарахаар шийдлээ” гэж шулуухан

хэлэх ёстой байсан юм гэв.

-Энэ амьдралд бүх юм санаснаар болохгүй шүү дээ гэж хурандаа өчив. Эхнэр нь тэр өдөр гэр орны ажил гээд амьсгаа дарах завгүй байлаа.

-Чи ерөөсөө ажил төрөл хийж сурахгүй юм. Ямар нэгэн юмыг зарахдаа яг л худалдан авч байгаа юм шиг дүр эсгэх хэрэгтэй гэж түүнийг ухуулахад хурандаад энэ байдал инээдэмтэй санагдав.

-Чи үргэлж л ингэж яваарай. Иймэрхүү байдлаар бол чи яг л овъёосны сурталчилгаанд гардаг тэр хүний оронцог шиг харагдах болно шүү гэж тэрбээр түүний яриаг таслав.

Тэрээр толгойныхоо алчуурыг авлаа.

-Чамд би үнэн сэтгэлээсээ хэлж байна. Би одоохон тэр эрхэмд тахиаг аваачиж өгөөд хагас цагийн дараа гэхэд бөөн мөнгөтэй эргэж ирнэ гэдэгтээ итгэлтэй байна.

-Чиний толгойд 900 песо л бодогдоод байнаа даа гэж хурандаа унтууцав. Тэрбээр түүнийг ятгах гэж ихэд чармайлт гаргав. Хурандаа өглөөний турш энэ мөнгөөр гурван жилийн турш ямар нэгэн зовлонт баасан гаригийг хүлээж өөрсдийгөө тарчлаалгүй амьдарч болно гэдгийг тооцоолсон байлаа. Эзэгтэй тэр их мөнгөний сургаар гэр орноо дахин цэвэрлэснийг хүртэл яана?! Чингэхдээ зайлшгүй авах зүйлсийн жагсаалтыг гаргахдаа нөхөртөө авах шинэ гутлыг ч бас мартсангүй. Унтлагын өрөөгөө хүртэл шинжээд шинээр авах толио хаана өлгөхөө ч тооцсон байв. Түүний гаргасан энэ бүх төлөвлөгөө бүтэхгүй байж

болох тухай бодол ичих хийгээд харамсах сэтгэлийг нэгэн зэрэг төрүүлжээ. Дараа нь тэр бага зэрэг хэвтэж амрав. Түүнийг босоход хурандаа саравчинд сууж байлаа.

-Чи наанаа юу хийж байгаа юм бэ?

-Би юм бодож байна гэж хурандаа хариулав.

-Тэгвэл одоо асуудал шийдэгдсэн юм байна. Тавин жил өнгөрөөгүй ч гэсэн бид энэ мөнгийг авах л юм байна шүү дээ. Гэвч мөн чанартаа өнөө орой хурандаа тахиагаа зарахаар шийдсэн байв. Тэрбээр ноён Сабасыг цахилгаан сэнс үлээлгэн сэрүүцэж, хэрхэн ээлжит тариагаа хийлгэхээр албан өрөөндөө сууж байгааг төсөөлөхдөө түүний юу хэлэхийг мэдэж байлаа.

-Чи тахиагаа аваад яв. Зуун удаа сонсохоор нэг удаа үзсэн нь дээр гэж эхнэрийгээ ятгахад хурандаа явахаас татгалзсан боловч авгай нь түүнийг үүд рүү гаргаж өглөө.

-Одоо түүний өрөөнд олон хүн байсан ч яахав дээ. Хамгийн гол нь чи түүний гараас бариад есөн зуун песо өгтөл нь ер холдож болохгүй шүү.

-Бид яг л эзлэлтэнд бэлтгэж байгаа мэт санагдах юм.

Гэвч тэрээр түүний үгийг ер анхаарсангүй.

-Тахианы эзэн бол чи өөрөө гэдгийг санах хэрэгтэй. Тиймээс чи л буулт хийж байна гэдгийг харуулах хэрэгтэй.

-За яахав, тэгэхээс дээ.

Ноён Сабас унтлагын өрөөндөө эмчийн хамт сууж байв.

-Эрхэм ээ, та одоо азаа туршаад үзээрэй. Эмч тэр хоёр ирэх долоо хоногт түүнийг хаашаа явах, юу хийх тухай ярилцаж байгаа юм гэж ноён Сабасын эхнэр хурандаад хэлжээ. Нэг талаас азарган тахиаг бушуухан зарахыг тэр шийдсэн боловч нөгөөтэйгүүр, ноён Сабасыг гэртээ байхгүй хойгуур ирэх нь ч зүгээр юм шиг санагдаж хурандаагийн санаа хоёрдож байлаа.

-Би хүлээсэн ч чадна гэж тэр хэлэв. Гэвч эзэгтэй түүнээс огтхон ч холдохгүй байлаа. Тэрээр нөхрийнхөө сууж байсан унтлагын өрөө рүү түүнийг дагуулж оров. Эмч өвтөний шээс бүхий шилэн савыг дээш өргөн гэрэлд хараад ноён Сабас руу харж хүндэтгэлтэйгээр толгой дохилоо.

-Түүнийг одоо буудах хэрэгтэй. Чихрийн шижин бол маш хүнд өвчин. Тиймээс бид хэзээ ч бүх баячуудыг цааш нь харуулж чадахгүй гэж хурандаад хандан эмч залуу хэлэв.

-Тайвшруулах тариагаар бөмбөгдсөөр байгаад та ч бараг санасандаа хүрч байна даа гэж ноён Сабас хэлээд,

-Гэхдээ би хатуу самар шүү.

Та ч хүнээ олсонгүй дээ гэснээ хурандаад хандаж:

-Эрхэм ээ, наашаа орооч.

Би өнөө өглөө таныг хайхаар завдсан боловч бүрх малгайг тань ч олж үзсэнгүй гэв.

-Би хүмүүсийн өмнө малгайгаа авч бөхөлзөхгүйн тулд хэзээ ч бүрх малгай өмсөж байсангүй.

Ноён Сабас хувцаслаж эхлэв. Эмч залуу хүрэмнийхээ халаасанд шилэн савтай цусны дээжийг хийлээ. Дараа нь тэр цүнхээ цэгцлэв. Хурандаа эмчийг явах гэж байна хэмээн бодлоо.

-Эмч ээ, таны оронд лав би байсан бол эрхэмээс 100 мянган песогийн төлбөр авах байлаа гэж хурандаа хэлэв.

-Гэвч би түүнд зөвхөн сая песогийн наймаа хийхийг санал болгосон. Ядуурал бол чихрийн шижин өвчнөөс хамгаалах хамгийн сайн эм гэж эмч хариулав.

-Жор хэлж өгсөнд баярлалаа. Гэвч би таныг баян болгох зовлонгоос чинь хамгаалахын тулд үүнийг дагаж мөрдөхийг хүсэхгүй байна гэж ноён Сабас хэлэв. Эмч бугуйн цагаа харав. Ноён Сабас гутлаа өмсөх зуур хурандаад хандаж:

-Эрхэм ээ, нөгөө тахиа юу болсон бэ? гэвэл, эмч түүний юу гэж хариулахыг ихэд сонирхож байгааг хурандаа анзаарав. Тэр аанай шүдээ хавирлаа.

-Эрхэм ээ, онцын юм болоогүй. Би зүгээр л түүнийг зарахаар ирлээ...

Ноён Сабас гутлаа өмсөөд босов.

-Сайн байна, эрхэм ээ. Үүнээс илүү ухаалаг шийдвэр гэж юу байх билээ.

-Би одоо хөгширчээ. Хорин жилийн өмнө байсан бол ч арай өөр байхгүй юу хэмээн хурандаа өөрийгөө зөвтгөж яриад эмчийн царайг ажив.

-Та үргэлж хорин нас залуу харагдах болно гэж эмч хариу барив. Хурандаа уртаар санаа алдлаа. Ноён Сабасыг өөр ямар нэгэн зүйл хэлэхийг хүлээсэн авч тэр юу ч дуугарсангүй. Харин цахилгаантай хүрмээ өмсөөд гадагш гарахаар завдав.

-Эрхэм ээ, хэрэв та хүсвэл энэ талаар ирэх долоо хоногт ярилцаж болох юм гэж хурандаа хэлэв.

-Би ч бас танд ийм санал тавих гэж байсан юм. Түүнийг чинь дөрвөн зуун песогоор авах нэг найдвартай хүн надад бий. Гэхдээ пүрэв гаригийг хүлээх нь зүйтэй болов уу гэж ноён Сабас ярив.

-Хэд ээ?

-Дөрвөн зуун песо.

-Би түүнийг чинь хамаагүй үнэтэй гэж сонссон шүү дээ гэж эмч залуу ярианд оролцов.

-Та чинь надад есөн зуун песо гэж хэлж байсан шүү дээ. Тэр тахиа бол ойр хавьдаа л хамгийн сайн

нь хэмээн эмчээс дэмжлэг авснаа ойлгомогц хурандаа унтууцав.

Ноён Сабас эмчид хандан:

-Урьд бол хэн ч гэсэн түүнийг мянган песо байсан чиг л авах байсан. Гэхдээ одоо бол ямар ч хүн сайн азарган тахиаг зодоонд оролцуулахад зориг дутна. Азарган тахианы зодооны үеэр одоо цагт духандаа сум зоолгох магадлал маш өндөр байна гэсээр тэр хурандаа руу эргэн харж ихэд өрөвдсөн байдалтайгаар:

-Эрхэм ээ, үүнийг л би танд хэлэх гэсэн юм гэв. Хурандаа толгой дохисноо:

-За яахав, тийм л байг гэжээ. Тэд явахаар зэхэв. Энэ үеэр ноён Сабасын эхнэр эмчийг дуудаж ямар нэгэн зүйл лавлаж байлаа. Хурандаа түүнийг албан өрөөнд хүлээзнэв. Ноён Сабас мөнгөний төмөр авдрыг онгойлгож өөрийн халаасыг мөнгөөр дүүргээд хурандаад ч бас хэдэн ширхэг цаасан мөнгө сарвайлаа.

-Эрхэм ээ, энд жаран песо байгаа. Тахиагаа зарчихаад өгнө биз гэж тэрбээр хэлэв.

Хурандаа эмчийн хамт хотхоны худалдааны дүүргээр явах үед оройн сэрүү орж байлаа. Чихрийн нишингэ ачсан ачааны усан онгоц голын урсгал дагуу хөвөх ажээ. Эмч яагаад ч юм хэт дуугүй нэгэн болсон мэт санагдана.

-Эмч ээ, та зүгээр үү?

Тэрбээр мөрөө хавчив.

-Урьдын л адил байна. Гэхдээ би ч гэсэн эмчид үзүүлэхэд илүүдэхгүй юм шиг санагдаж байна.

-Энэ бол өвөл шүү дээ. Миний дотор ч гэсэн зүгээр болчихсон шиг байна гэж хурандаа өгүүлэв.

Эмч хархүү өвгөн рүү анхааралтай харсан боловч түүний харцанд мэргэжлийнхээ ажлыг хийх ямар нэг сонирхол ажиглагдсангүй. Дараа нь тэр лангууныхаа үүдэн дээр сууж байсан сирийн худалдаачидтай мэндлэв. Эмнэлэгт дөхөж ирмэгц хурандаа түүнд ямар учраас азарган тахиагаа зарах болсон тухай тайлбарлахыг хүсчээ.

-Надад өөр арга зам алга даа. Энэ амьтан хүний махаар хооллодог юм.

-Хүний мах зооглодог ганцхан амьтан бол ноён Сабас. Тэр тахиаг аваад цааш нь үнэ өсгөж есөн зуун песогоор зарна гэдэгт би итгэлтэй байна гэж эмч хэлэв.

-Та тэгэж бодож байна уу?

-Тийм ээ. Тэр бол энэ тал дээр гаршсан нөхөр. Ямар сайндаа л чэрбитэй хуйвалдаж хор найруулсан байхав дээ.

Хурандаа үүнд итгэж ядна.

-Тэр ямбатан арьсаа хамгаалахын тулд юу ч хийхээс сийхгүй. Сабасыг башир аргаар л үзэл бодол нэгт намын нөхдийнхөө ихэнх эд хөрөнгийг худалдаж авсан гэлцдэг юм гэж эмч ярив.

Тэрбээр халаасандаа түлхүүр байхгүйг мэдээд хаалгаа тогшив. Дараа нь түүний ярьсанд үл итгэх хурандаад хандан:

-Та ийм гэнэн байж болохгүй шүү. Ноён Сабас өөрийн арьснаас илүү мөнгийг л чухалчилдаг хүн гэв.

Энэ орой хурандаагийн эхнэр хүнс цуглуулахаар явжээ. Түүнийг сиричүүдийн лангуу руу гаргаж өгөхдөө эмчийн хэлсэн бүхнийгхурандаа дахин дахин эргэцүүлэн бодлоо.

-Чи одоохон хүүхдүүдэд очиж тахиагаа худалдагдсан гэж хэл. Тэд дэмий хүлээгээд яахав дээ гэж эхнэр нь шийдэмгий мэдэгдэв.

-Ноён Сабасыг ирээгүй цагт тахиагаа би зарахгүй гэж хурандаа хариулав.

Тэрбээр бильярдын газар Альварог олж уулзлаа. Амралтын өдөр байсан тул тасалгаанд дүүрэн хүнтэй байх агаад байдаг чадлаараа дуугарах радиогоос болж эндхийн бүгчим агаар улам тэсвэрлэхийн аргагүй санагдана. Том ширээг бүтээсэн хар хулдаасан дээр зурайх тод тоонууд хурандаагийн анхаарлыг ихэд татжээ. Альваро хожигдож байсан ч хорин гурав дээр

бооцоогоо байнга тавьсаар байлаа.

Гэвч түүний аз энэ удаа шовойсонгүй тул өмднийхөө халааснаас мөнгө гаргахдаа ямар нэг нугалсан цаасыг гаргаж ирэн ширээн доогуураа түүнийг хурандаад дамжуулжээ.

-Үүнийг Агустин бичсэн юм.

Хурандаа ухуулга хуудсыг авч халааслав. Альваро арван нэг дээр томоохон бооцоо тавилаа.

-Бага багаар эхлээрэй гэж хурандаа түүнд зөвлөв.

-Та ч сайн мэдрэмжтэй юм аа гэж Альварог хэлэхэд хэд хэдэн тоглогчид өөр дугаараас бооцоогоо авч бас л арван нэг дээр тавьж харагдана. Хурандаагийн зүрх зогсох шиг болжээ. Тэрбээр амьдралдаа анх удаа маш их сэтгэл догдлон энэ бүхнийг ажиж зогслоо. Тав дээр буув.

-Харамсалтай л байна. Дэмий юманд хошуу бүү дүр гэдэг л болж байна даа гэж хэзээ ч засашгүй алдаагаа ойлгосон мэт хурандаа түүнд хэлэв. Апьваро түүн рүү огтхон ч харалгүйгээр инээмсэглэснээ:

-Хурандаа, та санаа зоволтгүй. Мөнгө хожоогүй ч гэсэн дурлал маань бүтэх байлгүй дээ гэв.

Гэнэт мамба бүжгийн ая зогсов. Бүхтоглогчид гараа өргөцгөөжээ. Энэ үеэр хурандаа түүний ард хэн нэгэн хүн буу тулган зогсохыг мэдрэв. Цагдаагийнхны гарт халаасандаа хууль бус ухуулах хуудас хийчихсэн байж байгаад баригдах нь тэр. Гараа өргөлгүй эргэн харахдаа хурандаа амьдралдаа анх удаа өөрийн хүүг буудсан хүнтэй нүүр тулсан байлаа. Эдүгээ энэ хүн түүний гэдсэнд буугаа тулгаж зогсоно. Тэрбээр нар, салхинд борлосон энэтхэг төрхтэй, намхан биетэй нэгэн байсан бөгөөд түүнээс яг л хүүхдийнх шиг үнэр ханхална. Хурандаа шүдээ хавираад хурууныхаа үзүүрээр бууны амсарыг холдуулав. Түүн рүү сарьсан багваахай лугаа адил бөөрөнхий жижигхэн нүд харж байлаа. Энэ нүд хоромхон зуур хурандааг зажлалгүй залгиад, нулимах шиг болсноо:

-Хурандаа, яв даа гэв.

Арванхоёрдугаар сар гарсан гэдгийг мэдэх гэж заавал цонхоо онгойлгох хэрэггүй байдаг. Хурандаа тахианыхаа хоолыг бэлтгэхээр гал зуухны өрөөнд жимс хэрчиж байхдаа хүйт орсныг голдоо ортол мэдрэв. Дараа нь тэр хаалгаа нээж өвс ногоо, модод хийгээд модон жорлонг ажигхуйд энэ бүгд газраас хөндийрөн агаарт жингүүдэж байгаа мэт санагдана. Эхнэр нь өглөөний есөн цаг хүртэл орондоо хэвтээд түүнийг гал зуухны өрөөнд орж ирэхэд хурандаа ойр зуурын зүйлийг цэгцэлж, азарган тахиаг тойрон бүчих хүүхдүүдтэй ярилцаж суулаа. Эзэгтэй зуух руу очихын тулд тэднийг тойрч гарах хэрэг гарав.

-Алив, зай тавиач. Энэ муу золигийн шувуунаас ер салахгүй нь л дээ гээд азарган тахиаг муухай харвал хурандаа эхнэрийнхээ уурлах болсон шалтгааныг ойлгохыг хүсэн тахиа руугаа ширтэв. Түүнийг уурлуулах ямар ч сэв тахианд ажиглагдсангүй агаад гагцхүү зодооны сургуулилт хийхэд бэлэн болсон нь илт мэдэгджээ.

-Зургийг нь авмаар ийм сайхан өглөө болж байхад тахианыхаа тухай мартаад цонхоор нэг хараач гэж хүүхдүүдийг явсан хойно хурандаа хэлэв.

Тэрээр цонхоор харсан боловч түүний царай хувирсан шинжгүй байлаа.

-Би нэг сарнай цэцэг ургуулж үзэх юмсан гэсээр эхнэрээ зуух руу дөхөхөд хурандаа сахпаа хусахаар жижигхэн толио хананд өлгөн,

-Сарнай ургуулахыг хүсч байгаа бол тарих л хэрэгтэй шүү дээ гэв.

-Тэднийг чинь тэгээд гахай идчихнэ шүү дээ.

-Тэр нь дээр байлгүй. Сарнайгаар тэжээгээд байвал гахай ч их баярлах байх даа. Тэрбээр толинд эхнэрээ харахад түүний царайнд ямар ч өөрчлөлт үл ажиглагдав.

Эхнэр нь гүн бодолд автан хэсэг дуугүйхэн сууснаа:

-Тэгээд л би цэцэг тарихгүй байгаа юм гэв.

-За, яахав. Тэгвэл битгий тарь гэж хурандаа хариулав. Түүний бие овоо дээрджээ. Арванхоёрдугаар сарын цаг агаараас болж гэдсэн дэх ургамал сэлт нь ч үхсэн бололтой. Гэхдээ өглөөгүүр тэр шинэ гутлаа өмсөх гэтэл эвгүй явдал болов. Хэдэн удаа бүтэлгүй оролдлого хийсний дараа чийдсэн гутлаа өмсчээ. Үүнийг анзаарсан эхнэр нь:

-Хэрэв чи шинэ гутлаа өмсөхгүй бол хэзээ ч түүнийгээ элээж барахгүй шүү гэжээ.

-Энэ гутал чинь саа өвчтэй хүмүүст зориулсан эд байна. Уг нь гутлыг нэг сар өмсчихөөд дараа нь зарах хэрэгтэй юм гэж хурандаа гэжив.

Гэрээс гарахдаа тэр өнөөдөр заавал ч үгүй захиа хүлээж авна гэдэгтээ тун итгэлтэй байлаа. Усан онгоц тосоход арай эрт байсан тул ноён Сабасынд түр хүлээзнэхээр шийджээ. Гэвч тэднийд очиход гэрийн эзнийг даваа гаригаас нааш ирэхгүй гэсэн үг сонсов.

Тэр энэ бүхэнд нэг их гутарсангүй.

-Эрт орой хэзээ нэгэн цагт ирэхдээ л ирнэ гэж бодсоор зогсоол тийш зүглэв.

Өглөөний цэнгэг агаарыг амьсгалахуйд дотор уужирч, сэтгэл сэргээсэн сайхан өдөр байлаа.

-Энэ сар тэр чигээрээ иймэрхүү байвал ч өөрийгөө яг л ариун тунгалаг болсон мэт мэдрэнэ дээ гэж сири эзний дэлгүүрт байхдаа дотроо шивнэв.

Дэлгүүрийн эзэн Моисей түүний бодлыг бараг л мартагдсан аялгуу болсон араб хэл рүүгээ чадан ядан хөрвүүлэв. Тэр бол дорно зүгийн төрхтэй, гөлгөр арьстай нэгэн агаад усанд живснээс болж хөдөлгөөний сааталд орсон, хөдөлж ядсан нэгэн байлаа. Түүнийг дөнгөж сая уснаас гаргаж ирсэн мэт санагдана.

-Библийн цаг үед яг тийм л байсан. Тэгвэл одоо би найман зуун ерэн долоон настай болж таарах нь. Харин та хэдтэй байх нь вэ? гэж түүнийг асуухад:

-Далан тав гэж шуудан зөөгчөөс харц үл салган хурандаа хариулав.

Хурандаа дөнгөж сая цирк ирснийг олж харлаа. Хэсэг зуур шуудан зөөгчөөс хараа салгаж усан онгоцон дээр байх олон арван хайрцган дундаас араатан амьтдыг эрж хайв. Гэвч амьтад байсангүй.

-Цирк иржээ. Сүүлийн арван жилийн дотор ирсэн хамгийн анхных нь гэж тэр хэлэв.

Дэлгүүрийн эзэн Моисей ч гэсэн өвгөний үгэнд итгэж байлаа. Тэрбээр эхнэртээ араб, испани хэл хольж ямар нэгэн юм хэлэв. Үүний хариуд эхнэр нь дэлгүүрийн гүнээс хариулж байлаа. Сири эр дотроо нэг зүйлийг бувтнаад түүний санааг юу зовоосон тухай хурандаад орчуулж хэлээд,

-Хурандаа, муураа нуугаарай. Хүүхдүүд циркэд худалдахаар түүнийг чинь хул гайлна шүү гэвэл хурандаа шуудан зөөгчийн араас ажиглаж сууснаа:

-Энэ циркэд амьтан байхгүй гэж дахин хэлэв.

-Энэ чухал биш. Тэр олсон дээр тэнцэгчид чинь ясаа хугалчихгүйн тулд муурын мах иддэг юм гэж сири эр мэдэмхийрлээ.

Хурандаа шуудан зөөгчийн араас даган худалдааны гудамжнаас талбай хүртэл алхлаа. Тэнд очмогц тахиан зодооны талбарын зүгээс олон хүний хашгиралдах чимээг сонсох үед хэн нэгэн түүний хажуугаар зөрөхдөө тахианых нь тухай асуужээ. Тэгэхэд л тэр яг өнөөдөр зодооны сургуулилт эхэлж байгааг санав. Тэрбээр шууданг тойрч, төдөлгүй тахиан зодоон сонирхогчдын дунд орлоо. Түүний азарган тахиа талбайн голд тун ганцаардсан, маш их айсан шинжтэй, хөл нь чичирхийлэн зогсож байлаа. Өрсөлдөгч нь үнсэн саарал өнгөтэй, гунигт автсан тахиа ажээ. Хурандаагийн сэтгэл ер хөдөлсөнгүй.

Хоёр тахиа хэдэнтээ мөргөлдөв. Нөр их алга ташилтын дор тэд дээр дороо орж хүзүү, хөлөөсөө хазалцах хийгээд өд нь энд тэндгүй таран хийсч байлаа. Хурандаагийн тахиа огт дайрсангүй.

Тэр саарал зүсмийн азарган тахианы дайралтыг хамгаалчихаад нөгөө л нэг байрандаа эргэн очоод зогсоно. Одоо түүний хөл чичрэхээ больжээ. Херман хайсыг даваад түүнийг дээш өргөж үзэгч олонд харуулав. Нижигнэсэн алга ташилт, энд тэндгүй орилох дуун сонсдоно.

Хурандаа эргэн тойрноо ажиглахад сэтгэл нь догдолсон үзэгч түмэн шатаар уруудан талбар руу дайрч байлаа. Улаа бутарсан, сэтгэл нь хөдөлж итгэл найдвартаа автсан хүмүүсийн царайг тэр ажиглаж зогсов. Тэд бол эндхийн хүмүүс биш байлаа. Урьд өмнө тэд хотхонд огтхон ч үзэгдэж байгаагүй. Тэрбээр хайсыг давж хүмүүсийн дундуур зайчлан явахдаа Херманы тайван, тогтуун харцыг олж харав. Тэд бие биеэ нүд цавчилгүй харцгаалаа.

-Оройн мэнд хүргэе, хурандаа.

Хурандаа түүнээс азарган тахиагаа аваад,

-Оройн мэнд гэж бувгналаа.

Тэр хэзээ ч энэ тахиа шигээ амьд амьтныг гартаа барьж байгаагүй мэт санав.

-Та гэртээ яагаад байсангүй вэ? хэмээн Херман өөрийгөө зөвтгөн асуулаа.

Хүмүүс энд тэндгүй алга нижигнүүлэн ташина. Хурандаагийн бие эвгүйрхэхэд хурсан олны дундуур зайчлан явсаар арайхийн гудамжинд гарчээ.

Ядуусын хорооллын оршин суугчид бүгд л гудамжинд гарцгаачихсан, бөөн хөвгүүд дагалдан гүйсэн хурандааг ажиглаж байлаа. Төв талбайн голд хүзүүндээ могой ороосон үлэмж биетэй хар арьстан эр зогсох хийгээд тэрбээр ямар ч зөвшөөрөлгүй эм, тариа худалдаалж зогсоно. Түүнийг тойрч бүчсэн хүмүүс тахиагаа сугавчилсан хурандааг харуут бүх анхаарлаа түүн рүү шилжүүлэв. Хурандаагийн хувьд гэртээ хүрэх зам хэзээ ч ийм хол мэт санагдаж байсангүй. Гэсэн ч хурандаа үүнд огт харамссангүй. Энэ хотхон сүүлийн арван жилийн турш ямар нэгэн нойрмог байдалд авгсан байлаа. Энэ өдөр захидал ирээгүй бас нэгэн баасан гариг байсан ч хүмүүс нойрноосоо сэржээ. Хурандаа өнгөрсөн цаг үеэ эргэн дурсав. Тэрбээр эхнэр, хүүхдийн хамт бороо орсныг үл анзааран шүхрээ барьсаар кино үзэж дуусгаснаа ч саналаа. Мөн үсээ толийтол самнасан намынхаа удирдагчдыг ч эргэн дурсчээ. Харин түүний дотор яг л бөмбөр нүдэх мэт өвчин нь шаналгаж байлаа. Голын харалдаа гудамжийг гэтлэн явахдаа дээхэн үед сонгуульд оролцохоор цугласан бөөн хүмүүс байхыг олж харав. Тэд бүгд хэрхэн цирк ирж буйг харцгаана. Нэгэн эмэгтэй лангууныхаа араас түүнд тахианы талаар юу ч юм орилон асуулаа. Гэвч тэрбээр өнгөрснөө эргэн дурсах тул түүний үгийг сонсох манатай явав. Гэрийнхээ үүдэнд хүрмэгц тэр хөвгүүдэд хандаж:

-За, одоо гэр гэртээ харьцгаа. Тэгэхгүй бол суран тэлээний амт үзүүлнэ шүү гэв.

Тэрбээр хаалгаа түгжиж гал зуухны дэргэдүүр

өнгөрөв. Эхнэр нь унтлагын өрөөнөөс амьсгаадсаар гарч ирээд:

-Түүнийг тэд аваад явчихсан. Намайг амьд байгаа цагт тахиа маань хэзээ ч энэ гэрийг орхихгүй гэж би тэдэнд зөндөө хэлсэн хэмээжээ.

Хурандаа зуухны хөлнөөс тахиагаа уяж, тахианы тавагтай усыг солиход эхнэр нь тун их бачимдсан байдалтай:

-Тэд намайг үхсэн ч бай тахиаг маань аваад явцгаана гэсэн. Энэ тахиа манайх биш харин бүх хотынхны өмч юм байх аа гэв.

Хурандаа эхнэрийнхээ балмагдсан царайг ажингаа,

-Зөв л хэлсэн байна. Азарган тахиагаа зарахгүй ээ гэж тайван хэлэв. Тэгээд түүний араас унтлагын өрөө рүү орлоо. Хурандаа урьдын адил байсан боловч тэр түүнийг гэртээ алсаас яг кино дэлгэцэн дээр байгаа мэтээр харж байлаа.

Хурандаа ханын шүүгээнээс мөнгөө гаргаж халаасанд байсныг дээр нь нэмж тоолж үзсэнээ буцааж шүүгээндээ хийв.

-Энд яг хорин есөн песо байна. Үүнийг ноён Сабаст эргүүлж өгөх хэрэгтэй. Үлдсэнийг нь тэтгэврээ авахаар өгнө гэж тэр хэллээ.

-Хэрэв ирэхгүй бол яах вэ?

-Ирнэ ээ.

-Гэхдээ л ирэхгүй бол яах вэ?

-Тэгвэл өгөхгүй л гэсэн үг.

Хурандаа орон доороос өөрийн шинэ гутлыг эрж олуутаа ханын шүүгээнээс цаасан хайрцаг гаргаж гутлынхаа улыг алчуураар арчаад хайрцганд хийлээ.

Эхнэр нь ер хөдөлсөнгүй.

-Одоо гутлыг эргүүлж өгөх хэрэгтэй. Тэгвэл эрхэмд нэмээд арван гурван песо өгчих боломжтой юм гэж хурандаа хэлэв.

-Түүнийг чинь авахгүй ээ.

-Авах л ёстой. Би ердөө хоёрхон удаа л өмссөн юм чинь...

-Түрэгүүд үүнийг чинь ойлгохгүй шүү дээ.

-Ойлгох л ёстой.

-Тэд ойлгодоггүй юм аа.

-Тэгвэл ойлгохгүй л байна биз.

Тэд оройн хоол идэлгүй унтахаар хэвтэцгээж, хурандаа эхнэрийгээ эрхиэ эргүүлж дуусмагц дэнлүүгээ унтраахаар хүлээзнэв. Гэвч ер унтаж чадсангүй агаад гурван цагийн дараа комендатын цагийг сануулж бүрээн ДУУ дуугарах хүртэл орондоо хөлбөрчээ. Үүр цайхаас өмнө жавартай хүйтэн агаараас эхнэр нь амьсгал авах нь түүний бие улам бүр хүндэрснийг илтгэнэ. Тэрээр нөхөртэйгээ тайван хийгээд эвлэрэнгүй байдалтай ярьж эхлэх агшин хүртэл хурандаа ер дугхийсэнгүй.

-Чи унтаагүй юм уу?

-Үгүй.

-Чи ойлго л доо. Маргааш ноён Сабастай ярилцах хэрэгтэй гэж эхнэр нь ятгав.

-Тэр даваа гаригаас нааш ирэхгүй.

-Тэгвэл сайн л биз, чамд бүгдийг бодоход гурван хоног байна.

-Надад өөр бодоод байх юм байхгүй гэж хурандаа гэжлөө.

Аравдугаар сарын чийглэг агаар арванхоёрдугаар сарын цэвэр агаараар солигдов.

Шөнийн хоёр цаг болж байсан ч хурандаа унтаагүй л байлаа. Тэр эхнэрийгээ бас л нойрсоогүй гэдгийг мэдэж байв. Түүнийг дүүжин орон дээрээ биеэ хөрвөөхөд:

-Чи бас унтаагүй юм уу? гэж эхнэр нь асуулаа.

-Үгүй ээ.

Тэрээр хэсэг дуугаа хурааснаа:

-Энэ бол бидний хувьд урьд өмнө үзээгүй тансаг явдал. Бидэнд дөрвөн зуун песо гэдэг юу болохыг төсөөлөөд үз дээ гэв.

-Тэтгэвэр ирэхэд маш бага хугацаа үлдлээ гэж хурандаа хэлэв.

-Чи арван таван жилийн турш л үүнийгээ улиг болтол давтан ярилаа.

-Ийм учраас л маш бага хугацаа үлдэж байгаа юм гэж хурандаа зөрүүдлэв.

Тэрээр дуугаа хураажээ.

-Миний бодлоор бол чиний мөнгө хэзээ ч ирэхгүй хэмээн эхнэр нь дахин ярьж эхлэхэд хурандаагийн хувьд цагийн зүү яг л нэг байрандаа хөдөлгөөнгүй зогсох шиг болов.

-Ирнэ ээ.

-Хэрэв ирэхгүй бол яах юм?

Хурандаа хариулахыг үл хүсэв. Азарган тахиа донгодох тэр мөчид тэрбээр бодит байдалдаа эргэн ирж, элдэв бодлоос салаад гүн нойрондоо автав.

Түүнийг сэрэхэд наран хэдийнэ дээр мандсан байлаа. Эхнэр нь унтсаар л байх... Хурандаа өглөөгүүр хийдэг зүйлээ амжуулчихаад эхнэрээ сэрэхлээр өглөөний цайгаа уухаар хүлээнэ.

Түүнийг гал зууханд ороход тэд хэн хэндээ өглөөний мэнд хүргэснээс өөр юу ч ярилцсангүй. Хурандаа аяга хар кофе ууж, чихэртэй талхыг жаахан бяслагтай идэв.

Бүхий л өглөөний турш тэрбээр гутал засварын газар өнжөөд өдрийн нэг цагт гэртээ иртэл эхнэр нь хэрэгтэй, хэрэггүй баахан хувцас хунар гаргачихсан сууж байлаа.

-Өдрийн хоол идэх цаг болжээ гэж түүнийг хэлэхэд:

-Идэх юм юу ч байхгүй гэж эзэгтэй хариулжээ.

Тэр мөрөө хавчив. Тэгээд хашааны завсраар хүүхдүүд орж гарахгүйн тулд цоорхойг нь сайтар бөглөжээ. Түүнийг эргэн гэртээ ортол ширээ зассан байлаа.

Хооллох үеэр эхнэр нь уйлчихгүйн тулд ихээхэн мэрийж байгааг тэр анзаарав. Энэ бүхэн түүнийг ихээхэн түгшээжээ. Тэрбээр эхнэрийнхээ зан байдлыг сайн мэдэх бөгөөд өнгөрсөн дөчин жилийн дотор ямар их зовлон зүдгүүрийг даван туулж хэрсүүжсэн болохыг нь ч сайтар ойлгож байлаа. Хүүгээ нас барахад ч тэр нэг дусал нулимс унагаагүй билээ.

Хурандаа түүний нүд рүү эгцлэн ширтвэл эзэгтэй уруулаа хазалж, нүднийхээ буланг ханцуйгаараа шударснаа хоолоо идэж эхлэв.

-Чи ч намайг бүр тоохгүй байх шив дээ гэж түүнийг хэлэхэд хурандаа юу ч дуугарсангүй.

-Би чамтай бүх амьдралаа хамт туулсан. Гэтэл одоо би чиний хувьд тэр муу тахианаас дор нэгэн болсон юм байж.

-Энэ бол өөр зүйл шүү дээ гэж хурандаа хэлэв.

-Өөр зүйл биш ээ. Эцсийн эцэст чи намайг үхэх гэж байгааг ойлгож байна уу?

Хурандаа нэг ч үг хэлсэнгүй.

-Тахиагзарснаар чиний багтраа өвчин эдгэрнэ гэсэн баталгааг эмч гаргаж өгвөл би түүнийг тэр дор нь зарна.

Хэрэв үгүй бол ер зарахгүй.

Өдөр нь тэрбээр зодооны талбар руу тахиагаа авч явав. Түүнийг эргэн ирэхэд эхнэрийнх нь өвчин хэдийнэ хөдөлчихсөн бололтой хонгилоор нааш цааш гараа хаялан алхаж, амаараа агаар залгин ихэд шаналсан байдалтай харагдана.

Унтахаар хэвтэхдээ тэр нөхөртөө нэг ч үг хэлсэнгүй. Харин комендатын цаг өнгөрсний дараа ч мааниа бувгнасаар л байлаа. Хурандаа дэнлүүг унтраахаар шийдвэл эхнэр нь эсэргүүцэж,

-Би харанхуйд үхмээргүй байна гэж хэлэв.

Хурандаа дэнлүүг авч дахин газар тавив. Тэрбээр яах ч учраа олсонгүй. Үүний оронд бүхнийг умартаж нэгмөсөн дөчин дөрвөн хоног тасралтгүй унтчихаад нэгдүгээр сарын хорины өдрийн гурван цагт тахиан зодоон болох тэр мөчид сэрвэл дээр мэт санагджээ. Эхнэр нь унтахгүй байсан тул тэр ч бас нойрсож чадсангүй.

-Мөнхийн түүх юм даа. Бусад хүмүүс цадталаа идэж байхад бид өлсгөлөнгөөр үхэх гэж байдаг. Иймэрхүү байдлаар дөчин жил өнгөрлөө...

Хурандааг унтаж байгаа эсэхийг эхнэр нь асуух хүртэл тэрбээр юу ч дуугарсангүй.

-Биднээс бусад нь энэ азарган тахианд бооцоо тавиад их мөнгө хожих болно. Гэтэл бид түүнд нэг ч

сентаво тавих чадвар алга...

-Тахианы эзэн хорин хувийг нь авах эрхтэй байдаг юм.

-Сонгуул ийн үеэр чиний зовлогыг өчнөөн л зовоосон. Чи тэгэхэд томоохон тушаал дээр очих боломж байсан. Иргэний дайны үед амиараа дэнчин тавьжявсаны хувьд чи ахмад зүтгэлтний тэтгэврийг авах эрхтэй байсан. Одоо бүх хүмүүсийн амьдрал тэгширчихсэн байхад чи ганцаараа л өлсгөлөнгөөр үхэх гэж байна хэмээн эхнэр нь үг хаяв.

-Би ганцаараа биш ээ гэж хурандаа зөрөөд өөр ямар нэгэн зүйл нэмж хэлэхийг хүссэн авч нойрондоо дийлджээ. Харин эхнэр нь нөхрийгөө унтсан гэдгийг мэдтэл өөртэйгээ ярьсаар байлаа.

Үүр цайх үед хурандаа түүнийг дуудав. Тэрээр дэнлүүний гэрэлд яг л хий үзэгдэл мэт харагдах ажээ.

-Хоёулаа нэг юм бодох уу гэж хурандаа түүнээс асуулаа.

-Бидний чадах ганцхан зүйл бол азарган тахиаг зарах явдал!

-Бид цагаа зарж болно шүү дээ.

-Түүнийг чинь хэн ч авахгүй.

-Маргааш би ноён Альварод дөчин песогоор зарах гэж оролдоё.

-Тэр авахгүй ээ.

-Тэгвэл ханын зургаа заръя.

Эхнэр нь орноосоо босч дахин үглэж гарав.

Хурандаа эмийн ургамалтай холилдсон түүний амьсгалыг мэдэрлээ.

-Түүнийг чинь хэн ч худалдаж авахгүй.

-Харж л байя. Одоо унт даа. Хэрэв маргааш юу ч

зарж чадахгүй бол юу хийхээ бодъё доо.

Тэрбээр хэсэг зуур юм бодож хэвтэх гэсэн боловч төдөлгүй унтчихав. Чингээд цаг хугацаа, орон зай ч үгүй, эхнэрийнх нь үг шал утгатай санагдах тийм л нэг орчин руу халин оджээ. Гэвч төдөлгүй түүний мөрөөс сэгсрэхийг мэдрэв.

-Надад хариул даа.

Хурандаа эхлээд зүүдэлж байна уу, эсвэл сэрүүнээр сонсож байна уу гэдгийгээ тэр да-

руй ойлгосонгүй.

Үүр цайж байлаа. Цонхоор бүтэн сайн өдрийн өглөөний наран тусчээ. Чичрэнгэ өвчин туссан мэт зовхи нь халуу шатаж, ухаан санаа нь орж гарч байх шиг санагдав.

-Хэрэв бид юу ч зарж чадахгүй бол яах болж байна аа? гэж эхнэр нь бас л нөгөө гунигт яриагаа өдвөл,

-Тэгвэл ч нэгдүгээр сарын хориньг хүлээнэ дээ. Хорин хувийг тэр өдөр нь л өгдөг юм гэжхэлээд хурандаа нойрноосоо бүрэн сэрэв.

-Тахиа чинь ялсан тохиолдолд л хувь хүртэнэ шүү дээ. Харин ялагдвал яах вэ? Чи түүнийг ялагдана гэдгийг тооцож үзсэн үү? гэж эхнэр нь шалгаалаа.

-Энэ азарган тахиа ялагдах учиргүй.

-Гэхдээ л чи ялагдчихвал яах вэ гэдгийг төсөөлөөд үзээч...

-Энэ тухай дөчин тав хоногийн дараа л бодох шаардлага гарна гэж хурандаа хэлвэл эхнэр нь уурлаж,

-Энэ бүх хугацаанд бид тэгээд юу хийх болж байна? Бид юугаа идэх болж байна аа? Чи хариулаач! гэсээр хурандаагийн цамцны захаас зуурч байдгаараа сэгсчиж гарлаа.

Хурандаагийн хувьд өөрийн амьдралын далан таван жилийг хормоос хоромд, энэхүү агшинг хүртэл амьдрахын тулд далан тав наслах шаардлагатай байсанж. Тэрбээр өөрийгөө хэзээ ч ялагдашгүй нэгэн хэмээн санах тул,

-Ялгадсаа л идэхгүй юү! гэж хариулжээ.

Table of Contents

[Габриэль ГАРСИЯ МАРКЕС](#)